685	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	61370025	Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээ	TMA-TMW03	Уламжлалт анагаах ухаан	0.044	21,000	-	21,000	21,000	-	21,000
686	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	61370026	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээ	TMA-TMW03	Уламжлалт анагаах ухаан	0.333	159,000	-	159,000	159,000	-	159,000
687	Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ	61390001	Сувиллын тусламж, үйлчилгээ		Сувиллын тусламж, үйлчилгээ	1.000	265,200	-	265,200	265,200	-	265,200

688	Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ	61390002	Сувиллаас үзүүлэх уламжлалтын тусламж, үйлчилгээ	TMA00- TMU07	Сувиллын тусламж, үйлчилгээ		1.600	424,300	-	424,300	424,300	-	424,300
689	Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ	61390003	Сувиллаас үзүүлэх сэргээн засахын тусламж, үйлчилгээ	Z50.1, Z50.4, Z50.5, Z50.7, Z50.8, Z50.9	Сувиллын тусламж, үйлчилгээ		1.539	408,100	-	408,100	408,100	-	408,100

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН АРГА

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн даатгалын сангаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг худалдан авахад баримтлах төлбөрийн аргыг тогтоох, төлбөрийн аргын бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох, бүрэлдэхүүн хэсэгт өөрчлөлт оруулах нөхцөлийг тогтооход оршино.

Хоёр. Төлбөрийн арга

2.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 заалтад зааснаас бусад эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг “Тохиолдолд суурилсан төлбөрийн арга”-аар тооцон санхүүжүүлнэ.

2.2 “Тохиолдолд суурилсан төлбөрийн арга” гэж Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-т¹ заасныг ойлгоно.

2.3 “Оношийн хамааралтай бүлэг” нь тохиолдолд суурилсан төлбөрийн аргын нэг хэлбэр бөгөөд өвчин эмгэгийг эмнэлзүйн хувьд төстэй, өртгийн хувьд ойролцоо байдлаар нь сонгон багцалж бүлэг үүсгэх, бүлэг бүрийн дундаж өртгийг урьдчилан тооцож, урьдчилан тогтоосон өртгөөр тухайн бүлэгт хамаарах бүх тусламж үйлчилгээг санхүүжүүлдэг арга юм.

2.4 “Оношийн хамааралтай бүлэг”-ийн төлбөрийн арга нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.4.1 Оношийн хамааралтай бүлгийн код: Бүлэг нь тусламж, үйлчилгээний нийтлэг онцлогийг илтгэх 9 хүртэлх цифрээс бүрдсэн кодтой байх бөгөөд кодын орон нь дараах утгыг илэрхийлнэ:

¹ “тохиолдолд суурилсан төлбөрийн арга” гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тохиолдол бүрээр зардлыг урьдчилж багцлан тооцож санхүүжүүлэхийг хэлнэ.

2.4.1.1 эхний орон нь “Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ”-ний төлбөрийн аргын хөгжүүлэлтийн хувилбарын дугаарыг;

2.4.1.2 хоёр дахь орон нь тухайн тусламж, үйлчилгээг үзүүлбэл зохистой эрүүл мэндийн байгууллагын төрлийг (1 – бүх ЭМБ, 2 – үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ортой болон оргүй клиник, амаржих газар, 3 – төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг)

2.4.1.3 дараагийн 2 орон буюу 3, 4 дэх орон нь тухайн бүлэгт хамрагдах оношийн үндсэн ангилал буюу эрхтэн системийн бүлгийн дугаарыг;

2.4.1.4 дараагийн 3 орон буюу 5, 6, 7 дахь орон нь тухайн бүлэгт орсон оношийн эмнэлзүйн төстэй байдлыг;

2.4.1.5 сүүлийн 2 орон буюу 8, 9 дэх орон нь тухайн тусламж, үйлчилгээний хэлбэрийг.

2.4.2 Тухайн бүлэгт хамаарах өвчин эмгэгийн оношийн жагсаалт: Бүлэгт эмнэлзүйн болон өртгийн хувьд ойролцоо оношуудыг жагсаан оруулсан байна. Жилд 20-иос доош удаа тохиолдсон өвчин эмгэгийг эмнэлзүйн болон өртгийн хувьд ойролцоо эсэхийг үл харгалзан нэгтгэж “Ангилагдаагүй бусад” гэсэн бүлэгт хамааруулна.

2.4.3. Суурь тариф: ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний өртгийн судалгаа, бодлогын тохируулгын өөрчлөлт, эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл зэрэгт үндэслэн тусламж, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно.

2.4.4. Өртгийн жин: Тухайн оношийн хамааралтай бүлгийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлогч индекс бөгөөд энэ нь тухайн бүлэгт хамаарах тусламж, үйлчилгээний дундаж өртгийг суурь тарифт харьцуулсан харьцаагаар тодорхойлогдох тул бүлэг бүрээр ялгаатай байна.

2.4.5. Бүсчлэлийн коэффициент: Аймаг, орон нутгийн алслагдмал байдал нь бараа бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслийн үнийг өсгөж, тусламж, үйлчилгээний өртгийг нэмэгдүүлж байгаа нь алслагдмал бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагаас чанартай тусламж, үйлчилгээг батлагдсан тарифаар даатгуулагчдад үзүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Уг нөлөөллийг арилгах зорилгоор холбогдох эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэхэд энэхүү коэффициентийг ашиглана. Бүсчлэлийн коэффициент нь тухайн бүс тус бүрээр ялгаатай байх бөгөөд тухайн бүс нутгийн Улаанбаатар хотоос алслагдсан байдлыг харгалзан тогтоогдоно. Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүд болох Налайх, Багануур, Багахангай дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд нь төвийн бүсчлэлд хамаарна.

2.4.6. Орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс: Монгол Улсын Засгийн газраас орон нутгийг дэмжих, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах болон орон нутагт ажиллах сонирхлыг бий болгох зорилгоор бий болгосон төрийн албан хаагчдад олгож буй цалингийн нэмэгдлийг тусламж, үйлчилгээний өртөгт тусгахад энэхүү индексийг ашиглана. Орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс нь Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүд болох Налайх,

Багануур, Багахангай дүүрэгт байршин үйл ажиллагаа явуулах төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад хамаарна.

2.5. Тухайн оношийн хамааралтай бүлэгт хамаарах нэгж тохиолдлыг санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ нь:

- А.** Төрийн өмчийн, орон нутагт оршин үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагуудын хувьд бүлгийн суурь тариф, өртгийн жин, бүсчлэлийн коэффициент болон орон нутгийн нэмэгдлийн цалингийн нэмэгдлийн индексийн үржвэрээр тодорхойлогдоно.

$$Z_{охб} = C_{охб} * K_{охб} * R_{охб} * W_{охб}$$

Энд,

$Z_{охб}$ – тухайн бүлэгт хамаарах оношийн нэг тохиолдлын нийт төлбөрийн хэмжээ

$C_{охб}$ – суурь тариф

$K_{охб}$ – холбогдох оношийн хамааралтай бүлгийн өртгийн жин

$R_{охб}$ – бүсчлэлийн коэффициент

$W_{охб}$ – Орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс

- В.** Бусад эрүүл мэндийн байгууллагуудын хувьд бүлгийн суурь тариф, өртгийн жин, бүсчлэлийн коэффициентийн үржвэрээр тодорхойлогдоно.

$$Z_{охб} = C_{охб} * K_{охб} * R_{охб}$$

Энд,

$Z_{охб}$ – тухайн бүлэгт хамаарах оношийн нэг тохиолдлын нийт төлбөрийн хэмжээ

$C_{охб}$ – суурь тариф

$K_{охб}$ – холбогдох оношийн хамааралтай бүлгийн өртгийн жин

$R_{охб}$ – бүсчлэлийн коэффициент

Гурав. Суурь тарифыг өөрчлөх

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай жилийн батлагдсан төсөвт суурь тарифыг нэмэгдүүлэх төсвийн боломж байгаа бөгөөд дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн үед эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчилнэ. Үүнд:

3.1.1. Албан ёсны статистикаар жилийн инфляцын сүүлийн хоёр жилийн нийлбэр 10 хувиас давсан;

3.1.2. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн;

3.1.3. Америк долларын төгрөгтэй харьцах ханш сүүлийн 2 жилийн дотор 20 ба түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн;

3.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн тогтолцооны үнэлгээ болон тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанар, үр дүнд хийсэн судалгаагаар суурь тарифыг өөрчлөх шаардлагатай нь нотлогдсон.

3.2. Суурь тарифын өөрчлөлттэй уялдуулан оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг өөрчлөхгүй байж болно.

3.3. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар нь суурь тарифыг өөрчлөх шаардлагатай эсэх тарифыг нэмэгдүүлэх төсвийн орон зай эрүүл мэндийн даатгалын санд байгаа эсэхэд жил бүр дүн шинжилгээ хийж, энэ талаарх дүгнэлтийг шийдвэрлэх арга замын саналын хамт ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлнэ.

**ЭМД-ЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ТАРИФ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР**

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Суурь тариф
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	964,800
2	Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ	34,000
3	Яаралтай тусламж, үйлчилгээ	96,500
4	Түргэн тусламж, үйлчилгээ	51,100
5	Телемедицин	55,100
6	Өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ	254,600
7	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	742,600
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	933,500
9	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	477,400
10	Сувилаас үзүүлэх тусламж, үйлчилгээ	265,200

**ЭМД-ЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХОД БАРИМТЛАХ
БҮСЧЛЭЛИЙН КОЭФФИЦИЕНТ**

№	Бүсчлэл	Бүсчлэлийн коэффициент
1	Баруун бүс	1.15
2	Хангайн бүс	1.1
3	Төвийн бүс	1.05
4	Зүүн бүс	1.05
5	Улаанбаатар	1

**ЭМД-ЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ОРОН
НУТГИЙН ЦАЛИНГИЙН НЭМЭГДЛИЙН ИНДЕКС**

№	Орон нутгийн төрөл	Нэмэгдлийн индекс
1	Сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	1.18
2	Аймгийн төв болон Улаанбаатар хотын Багануур, Налайх, Багахангай дүүргийн төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд	1.08

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ХУДАЛДАН АВАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.10, 9.1.11, 9.1.13 -д заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.8, 24.6.10-т заасан төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээ (цаашид “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэх”)-ний төрлийг тогтоох, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар (ЭМДЕГ)-тай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага (ЭМБ)-аас иргэн, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС) болон төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах зориулалтаар эрүүл мэндийн даатгалын санд улсын төсвөөс шилжүүлж нэгтгэсэн сангаас санхүүжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг худалдан авах, санхүүжүүлэхдээ тухайн жилийн ЭМДС-ийн батлагдсан төсөвт багтаана.

Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл

2.1. Амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ:

2.1.1. Өвчний учир, үзлэг оношилгоо, шинжилгээ;

2.1.1.1. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ

2.1.1.2. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-А

2.1.1.3. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-В

2.1.1.4. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-С

2.1.1.5. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-Д

2.1.1.6. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-Е

2.1.1.7. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-Ф

2.1.1.8. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ-Эрхтэн шилжүүлэх

2.1.2. Амбулаторийн тусламж, үйлчилгээ:

2.1.2.1. Өвчний учир үзлэг;

2.1.2.2. Эрүүл мэндэд нөлөөлж буй нөхцөл байдал;

2.1.2.3. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэгийн үзлэг, оношилгоо

2.1.2.4. Амбулаториор хийгдэх мэс ажилбар

- 2.1.3. Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 - 2.1.3.1. Шүдний тусламж, үйлчилгээ
 - 2.1.3.2. Хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ
- 2.1.4. Амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо;
 - 2.1.4.1. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ
 - 2.1.4.2. Халдварт өвчний хяналт
 - 2.1.4.3. Сүрьеэ өвчний хяналт
 - 2.1.4.4. Халдварт бус өвчний хяналт-Бусад өвчнүүдийн хяналт
 - 2.1.4.5. Халдварт бус өвчний хяналт-Хоол боловсруулах замын эмгэгийн хяналт
 - 2.1.4.6. Халдвар бус өвчний хяналт-Дотоод шүүрлийн эмгэгийн хяналт
 - 2.1.4.7. Халдварт бус өвчний хяналт-Зүрх судасны эмгэгийн хяналт
 - 2.1.4.8. Халдварт бус өвчний хяналт-хорт хавдрын хяналт
 - 2.1.4.9. Халдварт бус өвчний хяналт-хорт хавдрын хяналт А
 - 2.1.4.10. Халдварт бус өвчний хяналт-Сэтгэцийн эмгэгийн хяналт
 - 2.1.4.11. Осол, гэмтлийн хяналт
 - 2.1.4.12. Мэс заслын эмчилгээний дараах хяналт
 - 2.1.4.13. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах хяналт
- 2.1.5. Амбулаторийн үзлэг, зөвөлгөө, хяналт
 - 2.1.5.1. Эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ
 - 2.1.5.2. Хүүхэд, өсвөр үеийн тусламж, үйлчилгээ
- 2.1.6. Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбар
 - 2.1.6.1. дурангаар хийх ажилбар
 - 2.1.6.2. судсан дотуур хийгдэх оношилгооны ажилбар
 - 2.1.6.3. судасны бус ажилбар
 - 2.1.6.4. цөмийн оношилгоо
 - 2.1.6.5. ПЭТ-КТ оношилгоо
 - 2.1.6.6. Оношилгоо, шинжилгээ
- 2.2. Өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ:
 - 2.2.1. гемодиализ;
 - 2.2.2. хэвлийн диализ;
 - 2.2.3. өдрийн эмийн эмчилгээ;
 - 2.2.4. өдрөөр хийх хорт хавдрын хими эмчилгээ;
 - 2.2.5. өдрөөр хийх хорт хавдрын туяа эмчилгээ;
 - 2.2.6. өдрийн мэс засал;
- 2.3. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:
 - 2.3.1. эрчимт эмчилгээ;
 - 2.3.2. эмийн эмчилгээ;
 - 2.3.3. мэс засал;
 - 2.3.4. эрхтэн шилжүүлэх мэс засал;

- 2.3.5. хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ.
- 2.4. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;
- 2.5. Сэргээн засах тусламж, үйлчилгээ:
 - 2.5.1. амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 - 2.5.2. өдрийн эмчилгээ;
 - 2.5.3. хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ.
- 2.6. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ:
 - 2.6.1. амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 - 2.6.2. өдрийн эмчилгээ;
 - 2.6.3. хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ.
- 2.7. Яаралтай тусламж;
- 2.8. Түргэн тусламж;
 - 2.8.1. ойрын дуудлага;
 - 2.8.2. алсын дуудлага.
- 2.9. Телемедициний тусламж, үйлчилгээ;
- 2.10. Сувиллын тусламж, үйлчилгээ.
 - 2.10.1.1. Сувиллаас үзүүлэх уламжлалтын тусламж үйлчилгээ
 - 2.10.1.2. Сувиллаас үзүүлэх сэргээн засахын тусламж, үйлчилгээ
 - 2.10.1.3. Сувиллын тусламж, үйлчилгээ

Гурав. ЭМДС-аас тусламж, үйлчилгээ худалдан авах, санхүүжүүлэхэд баримтлах зарчим

3.1. ЭМДС-аас чанартай тусламж, үйлчилгээ худалдан авах зарчмыг баримтлах бөгөөд ЭМДЕГ-ын чанар болон төлбөрийн хяналтын үйл ажиллагааны хүрээнд зөрчил илэрсэн нэгж тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхгүй.

3.2. ЭМБ-аас иргэнд үзүүлсэн дараах тусламж, үйлчилгээний зардлыг тухайн иргэн эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ. Үүнд:

- 3.2.1. яаралтай тусламж;
- 3.2.2. түргэн тусламж;
- 3.2.3. жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээ;
- 3.2.4. халдварт өвчний оношилгоо, эмчилгээ болон сүрьеэ,
- 3.2.5. сэтгэцийн эмгэгийн зарим тусламж, үйлчилгээ;
- 3.2.6. бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ,

3.3. Энэхүү журмын 3.2-т зааснаас бусад тохиолдолд зөвхөн эрүүл мэндийн даатгалтай иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ.

Дөрөв. ЭМБ-аас иргэн даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд

ЭМД-ын сангаас төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээг тооцох, санхүүжүүлэх

ЭМДС-аас төлбөл зохих төлбөрийн сарын нийт хэмжээг тооцох, санхүүжүүлэх:

4.1. ЭМБ-аас иргэн даатгуулагчид тухайн сард үзүүлсэн тусламж, үйлчилгээнд ЭМД-ын сангаас төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээ нь энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан тусламж, үйлчилгээний төрөл тус бүрийн сарын төлбөрийн хэмжээний нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

4.2. “Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц”-ын тухайн сарын нийт төлбөрийн хэмжээг тооцон санхүүжүүлэхдээ тухайн багцын нийт нэхэмжлэлд 1) MRI, CT оношилгоо хийсэн тохиолдлын нийт нэхэмжлэлийн тоонд эзлэх хувь нь суурь түвшинд хүрсэн эсэх, 2) MRI, CT оношилгоонд илгээсэн онош болон оношилгоогоор баталгаажсан онош хоорондын оновчтой байдлын хувь нь зорилтот түвшинд хүрсэн эсэхээс хамааруулж, **нэгж тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд суурилж тооцогдсон сарын нэхэмжлэлийн*** дүн дээр дараах аргачлалаар тооцсон дүнг санхүүжүүлнэ. Үүнд:

Хувилбар	MRI, CT оношилгоо хийсэн тохиолдлын нийт нэхэмжлэлийн тоонд эзлэх хувь	MRI, CT оношилгооны оновчтой байдлын хувь	Нэмэгдүүлэх санхүүжилтийн дүн
Хувилбар 1	Бүх оношилгооны хувьд тоо хэмжээний зорилтот түвшинд хүрсэн	Бүх оношилгооны хувьд оновчтой байдлын хувь нь зорилтот түвшинд хүрсэн	Нийт нэхэмжлэлийн тоо * тухайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээ
Хувилбар 2	Бүх оношилгооны хувьд тоо хэмжээний зорилтот түвшинд хүрээгүй /81-99%/	Бүх оношилгооны хувьд оновчтой байдлын хувь нь зорилтот түвшинд хүрсэн	Нийт нэхэмжлэлийн тоо * тухайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээ
Хувилбар 3	Бүх оношилгооны хувьд тоо хэмжээний зорилтот түвшинд хүрээгүй /81-99%/	Бүх оношилгооны хувьд оновчтой байдлын хувь нь зорилтот түвшинд хүрээгүй	Нийт нэхэмжлэлийн тоо * тухайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээ - (хийгээгүй оношилгооны тоо хэмжээ * оношилгооны нэгжийн үнэ /Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төлбөрийн хэмжээ/)
Хувилбар 4	Бүх оношилгооны хувьд тоо хэмжээний зорилтот түвшний 80 хувиас бага	Хамаарахгүй	(Нийт нэхэмжлэлийн тоо * тухайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээ) – (хийгээгүй оношилгооны тоо хэмжээ * оношилгооны нэгжийн үнэ /Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын

			хамтарсан тушаалын төлбөрийн хэмжээ/)
--	--	--	---------------------------------------

4.3. “Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц”-ын нэгж тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд суурилж тооцогдсон сарын нэхэмжлэлийн дүн нь энэхүү журам дахь нэгж тохиолдлын санхүүжилтийг тооцох удирдамжийн “Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц” хэсгийн 1.2-т заасан аргачлалаар тооцсон тохиолдол тус бүрийн олгох дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

4.4. “Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц”-ын тухайн сарын нэхэмжлэлийн 1) MRI, CT оношилгоо хийсэн тохиолдлын нийт нэхэмжлэлийн тоонд эзлэх хувь болон 2) MRI, CT оношилгоонд илгээсэн онош болон оношилгоогоор баталгаажсан онош хоорондын оновчтой байдлын хувийн зорилтот түвшин нь дараах байдалтай байна. Үүнд:

ОХБ код	Оношийн хамааралтай бүлгийн нэр	MRI, CT оношилгоо хийсэн тохиолдлын нийт нэхэмжлэлийн тоонд эзлэх хувь нь /суурь түвшин/		MRI, CT оношилгоонд илгээсэн онош болон оношилгоогоор баталгаажсан онош хоорондын оновчтой байдлын хувь /суурь түвшин/	
		MRI	CT	MRI	CT
51300014	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ – А	7%	26%	30%	30%
51300015	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ – В	4%	23%	30%	30%
51300016	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ – С	15%	9%	30%	30%
51300017	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ – D	-	13%	-	30%
51300019	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ – E	15%	44%	30%	30%
51300020	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ - F	9%	9%	30%	30%
51300048	Халдварт бус өвчний хяналт -Хорт хавдрын хяналт А	8%	26%	-	-

ЭМДС-аас төлбөл зохих төлбөрийн жилийн нийт хэмжээг тооцох, санхүүжүүлэх:

4.5. ЭМБ-аас иргэн даатгуулагчид тухайн жилд үзүүлсэн тусламж, үйлчилгээнд ЭМД-ын сангаас төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээ нь энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан тусламж, үйлчилгээний төрөл тус бүрийн жилийн төлбөрийн хэмжээний нийлбэр дүнгээр тодорхойлогдох бөгөөд ЭМДЕГ болон ЭМБ хооронд тухайн жилд байгуулсан гэрээнд тусгагдсан нийт санхүүжилтийн дүнгээр хязгаарлагдана.

4.6. ЭМДС-ийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ЭМБ-аас үзүүлсэн дор дурдсан тусламж, үйлчилгээг худалдан авах, төлбөрийн жилийн нийт хэмжээг тооцон санхүүжүүлэхдээ дараах аргачлалыг баримтална. Үүнд:

4.6.1. Түргэн тусламжийн тусламж, үйлчилгээг тухайн ЭМБ болон ЭМДЕГ хооронд тухайн жилд байгуулсан гэрээнд тусгагдсан тоо хэмжээгээр хязгаарлахгүйгээр чанар, төлбөрийн хяналтын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл (ЭМДҮЗ)-өөс баталсан төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ.

4.6.2. Дараах цочмог үеийн тусламж, үйлчилгээнүүдийг ЭМБ болон ЭМДЕГ хооронд тухайн жилд байгуулсан гэрээнд тусгагдсан тоо хэмжээ хүртэл ЭМДҮЗ-өөс баталсан зардлын хэмжээгээр, гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн тохиолдол тус бүрийг тусламж, үйлчилгээний төрлөөс хамаарч ЭМДҮЗ-өөс баталсан төлбөрийн хэмжээний 60-80 хувиар тооцон, нэхэмжлэлийн хяналтын үр дүнд үндэслэн санхүүжүүлнэ. Хэрэв хамтын төлбөр төлбөл зохих иргэний тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд уг 60-80 хувиар тооцсон төлбөрийн хэмжээнээс хамтын төлбөрийн хувь хэмжээг ахин бууруулж ЭМДС-аас санхүүжүүлнэ. Үүнд:

4.6.2.1. Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ

4.6.2.2. Яаралтай тусламж

4.6.2.3. Эрчимт эмчилгээ

4.6.2.4. Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээ

4.6.2.5. Ураг, нярайн тусламж, үйлчилгээ

4.6.2.6. Осол, гэмтлийн тусламж, үйлчилгээ

4.6.2.7. Яаралтай мэс засал

4.6.2.8. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

4.6.2.9. Цочмог өвчний үеийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

4.6.2.10. Сэтгэц, хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ

4.6.3 Эрхтэн шилжүүлэх тусламж, үйлчилгээ болон архаг өвчин, амьдралын чанарыг дээшлүүлэх хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, зарим төлөвлөгөөт мэс засал, уламжлалт, сэргээн засах тусламж, үйлчилгээ, амбулатори, өдрийн эмчилгээг санхүүжүүлэхдээ ЭМБ болон ЭМДЕГ-ын хооронд тухайн жилд байгуулсан гэрээнд тусгагдсан тоо хэмжээг мөрдөж, гэрээнд тусгагдсан тоо хэмжээ хүртэл нь санхүүжүүлнэ. Гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн тохиолдлыг худалдан авахгүй, санхүүжүүлэхгүй.

4.6.4. Энэхүү журмын 4.5.2 болон 4.5.3-ыг мөрдүүлэхэд баримтлах цочмог үеийн тусламж, үйлчилгээ, архаг өвчин, амьдралын чанарыг дээшлүүлэх хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, төлөвлөгөөт болон яаралтай мэс засалд хамаарах оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг тухайн тусламж,

үйлчилгээний эмнэлзүйд үндэслэн ЭМДЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн газар тодорхойлно.

4.7. Эрүүл мэндийн сайдын багцын батлагдсан урсгал төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуурыг ЭМБ-д олгосон тохиолдолд тухайн олгосон эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нийт зардлыг тухайн ЭМДС-аас олговол зохих төлбөрөөс хасаж санхүүжүүлнэ.

4.8. ЭМДЕГ нь тухайн эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр олгож болох бөгөөд энэ тохиолдолд үлдэгдэл санхүүжилтийг үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтын үр дүнг үндэслэн, нийт гүйцэтгэлийн дүнгээс олгосон урьдчилгаа санхүүжилтийн дүнг хасаж тооцон олгоно.

4.9. Эрүүл мэндийн байгууллагаас иргэн, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрт ЭМД-ын сангаас олговол зохих нийт санхүүжилт нь энэ журмын 4.7-д заасан урьдчилгаа төлбөрөөс бага тохиолдолд илүү олгосон урьдчилгаа төлбөрийг дараа сарын урьдчилгааны дүнгээс суутган шилжүүлж тооцно.

Тав. Иргэний хариуцан төлөх төлбөр

5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан Монгол улсын иргэн нь энэхүү журмын 5.2, 5.3-т зааснаас бусад тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан “ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-д заасан иргэний хариуцан төлөх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө.

5.2. Дараах иргэн энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан 53021152, 530211541, 530211542, 530804442, 530804443, 530821242, 530821243, 51300046, код бүхий оношийн хамааралтай бүлгээс бусад оношийн хамааралтай бүлэг, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцын хүрээнд хийгдсэн нэгжийн үнэ нь 45000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй оношилгоо, шинжилгээний² иргэний хариуцан төлөх төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд төлбөрийг тухайн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхээр ЭМДҮЗ-ээс баталсан нийт төлбөрийн хэмжээгээр ЭМД-ын сангаас ЭМБ-д бүрэн төлнө. Үүнд:

5.2.1. тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн /“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дахь заалтын дагуу тэтгэвэр авагчид/;

5.2.2. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн;

5.2.3. хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

5.2.4. хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;

5.2.5. ял эдэлж байгаа ялтан;

² Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан Төлбөртэй тусламж үйлчилгээний тарифыг баримтлана.

5.3. Монгол Улсын 0-18 насны хүүхэд энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-гээр баталсан бүх оношийн хамааралтай бүлэг, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний хүрээнд хийгдсэн нэгжийн үнэ нь 45000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй оношилгоо шинжилгээний² иргэний хариуцан төлөх төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд төлбөрийг тухайн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхээр ЭМДҮЗ-ээс баталсан нийт төлбөрийн хэмжээгээр ЭМД-ын сангаас ЭМБ-д бүрэн төлнө.

5.4. Нийт иргэн, даатгуулагч энэхүү журмын 5.1-д заасан иргэний хариуцан төлөх төлбөрөөс гадна дараах нэмэлт төлбөрийг өөрөө хариуцан төлнө:

5.4.1. ЭМБ болон даатгалын байгууллага хооронд байгуулсан гэрээгээр энэхүү журмын 4.6-т заасан шаардлагыг хангасан тусламж үйлчилгээний хувьд үнийн тохиролцоо хийж, гэрээнд тусгасан төлбөрийн хэмжээ болон тухайн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээний зөрүү төлбөр;

5.4.2. Даатгуулагч “Амбулаторийн цогц тусламж үйлчилгээ”-ний тусламж, үйлчилгээг тухайн эмнэлэгтээ бүрэн аваагүй буюу өөрийн буруугаас давтан үзлэг, нарийн мэргэшлийн эмчээс илгээсэн өөр нарийн мэргэшлийн эмчийн үзлэгт ороогүй бол тухайн эмнэлэгтээ дараагийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахдаа тухайн тусламж үйлчилгээний нийт зардлын 25 хувийг;

5.4.3. ЭМДС-аас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцоололд ороогүй, ЭМДЕГ болон ЭМБ хооронд байгуулсан гэрээнд тусгайлан заагдсан, иргэний хүсэлтийн дагуу үзүүлсэн нэмэлт үйлчилгээний төлбөрийг 100 хувь;

5.4.4. ОХБ-ийн жагсаалтад ороогүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг 100 хувь;

5.4.5. 0-6 насны хүүхдийн 5 хүртэлх шүд, 7-18 насны хүүхдийг 6 хүртэл шүд, жирэмсний хяналтад буй эмэгтэйн өвчилсөн бүх шүдний эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх бөгөөд бусад тохиолдолд болон насанд хүрэгчид шүдний эмчилгээний төлбөрийг холбогдох журмын дагуу өөрөө хариуцан төлнө;

5.4.6. Эрүүл мэндийн байгууллагад цаг авсан боловч тухайн цагтаа эрүүл мэндийн байгууллагадаа өөрийн буруугаас болж тусламж, үйлчилгээгээ аваагүй, цагаа товлот хугацаанаас 24 цаг ба түүнээс дээш хугацааны өмнө цуцлуулаагүй бол тухайн эрүүл мэндийн байгууллагад дахин дараагийн амбулаторийн тусламж үйлчилгээ авахад 20,000 төгрөг;

5.5. ЭМДЕГ нь дараах шаардлагыг бүхэлд нь эсхүл аль нэгийг нь хангасан тусламж, үйлчилгээний зөрүү төлбөрийн хэмжээг зайлшгүй тохиолдолд ЭМБ-тай гэрээгээр тохиролцож болно. Үүнд:

5.5.1. Даатгуулагчийн амь насыг аврах, цочмог үеийн тусламж, үйлчилгээ хэдий ч хүртээмж нь нэн хязгаарлагдмал, хүртээмжийг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээний хувьд;

5.5.2. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад багтсан өвчин эмгэгийн эмчилгээг нутагшуулсан бөгөөд түүнтэй холбогдох зарим зардал нь улсын төсөв болон ЭМДС-аас санхүүжигдээгүй тохиолдолд;

5.5.3. Даатгуулагчид нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлсэн бөгөөд уг технологид хамаарах зардал нь ЭМД-ын тусламж, үйлчилгээний тарифт шингээгүй тохиолдолд;

5.5.4. Тухайн тусламж, үйлчилгээг тухайн ЭМБ-аас өөр ЭМБ үзүүлдэггүй бөгөөд тухайн тусламж, үйлчилгээний өртөг нь ЭМДҮЗ-ийн баталсан төлбөрийн хэмжээнээс давсан тохиолдолд;

5.6. Энэхүү журмын 5.5-д заасан төлбөрийн хэмжээг нь ЭМБ-тай гэрээгээр тохиролцох тусламж, үйлчилгээ, шинэ технологийн жагсаалт, тухайн жилийн тоо хэмжээг ЭМДЕГ-ын даргын тушаалаар жил бүр батлах бөгөөд баталсан жагсаалт, тоо хэмжээний хүрээнд төлбөрийн хэмжээний тохиролцоо хийнэ. Хэрэв ЭМБ нь энэхүү журмын 5.5-д заасан шаардлагыг хангасан тусламж, үйлчилгээ үзүүлдэг хэдий ч төлбөрийн хэмжээний тохиролцоо хийх хүсэлт ирүүлээгүй тохиолдолд тухайн ЭМБ-ыг тус тусламж, үйлчилгээнд ЭМДС-аас санхүүжүүлэхээр баталсан төлбөрийн хэмжээг хүлээн зөвшөөрсөнд тооцон, тохиролцоо хийхгүй.

5.7. Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй даатгуулагч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа тухайн тусламж, үйлчилгээний нийт төлбөрийн хэмжээний **80** хувьтай тэнцэх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө. Монгол улсаас бусад улстай байгуулсан Нийгмийн хамгааллын гэрээ, хэлэлцээрт эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудлыг тусгасан тохиолдолд тухайн гэрээ, хэлэлцээрийн зохицуулалтыг баримтална.

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг

6.1. Эрүүл мэндийн байгууллага нь дараах тохиолдлуудад даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд тусгагдсан тоо хэмжээ дууссан гэх шалтгаанаар даатгалын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхийг санал болгох, үзүүлэхээс татгалзах, нэмэлтээр албан бус төлбөр авахыг хориглоно. Үүнд:

6.1.1. Энэхүү журмын 4.6.1-т заасан түргэн тусламж болон 4.6.2-т заасан гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тарифын 60-80%-иар санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ;

6.1.2. Энэхүү журмын 4.6.3-т заасан “эрхтэн шилжүүлэн суулгах” тусламж, үйлчилгээ;

6.1.3. Энэхүү журмын 4.6.3-т заасан “гэрээний тоо хэмжээг мөрдөж, гэрээнд тусгагдсан тоо хэмжээ хүртэл санхүүжүүлэх” тусламж, үйлчилгээний хувьд гэрээнд тусгагдсан тоо хэмжээ нь дуусаагүй байхад.

6.2. Эрүүл мэндийн байгууллага нь иргэн даатгуулагчдад тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэх хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

6.2.1. Гэрээгээр заасан тусламж, үйлчилгээний тоо хэмжээг жилийн турш хүртээмжтэйгээр иргэн даатгуулагчдад үзүүлэх, иргэн даатгуулагчдыг зөв оновчтой мэдээллээр хангах

6.2.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс олсон орлогыг даатгалын тусламж, үйлчилгээний тарифт шингэсэн зардлыг нэн тэргүүнд санхүүжүүлж, иргэний санхүүгийн хамгаалалтыг сайжруулах

Долоо. Бусад

7.1. Эрүүл мэндийн байгууллага (ЭМБ) нь иргэнд энэхүү журмын 2.3.1 (эрчимт эмчилгээ), 2.7 (яаралтай тусламж А), 2.8 (түргэн тусламж), 2.9 (телемедицин), 2.2.2 (хэвлийн диализ), 2.4 (хөнгөвчлөх)-т зааснаас бусад тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрдээ тусламж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн болон дууссан хугацааг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбосон хурууны хээ уншигч төхөөрөмжөөр, хэрэв тийм боломжгүй бол ОТР баталгаажилт болон бусад орчин үеийн дэвшилтэт аргыг ашиглан, төрийн мэдээлэл солилцох цахим системээр баталгаажуулна.

7.2. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний удирдамжид зааж өвчний түүх болон холбогдох бүртгэлд бичигдсэн бөгөөд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, мэс заслын хэрэгсэл, протезыг зайлшгүй шаардлагаар иргэнээр зардлыг гаргуулсан тохиолдолд худалдан авсныг нь нотлох и-баримт дахь үнээр тооцож иргэнд заавал буцаан олгоно.

Найм. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

8.1. Эрүүл мэндийн байгууллага даатгуулагчид шаардлагагүй эмчилгээ, үйлчилгээ санал болгох, холбогдох оношийг өндөр өртөг бүхий оношийн бүлэг рүү хувирган нэхэмжлэх зэрэг хууран мэхлэх зөрчил гаргасан нь нотлогдсон бол холбогдох хууль, журам, гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

8.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмын 5 дугаар бүлэгт заасан “Иргэний хариуцан төлөх төлбөр”-өөс өөр төлбөрийг иргэнээс авсан тохиолдолд иргэнээс авсан нэмэлт төлбөрийн хэмжээтэй дүйцэх санхүүжилтийг дараагийн санхүүжилтээс бууруулах, дахин давтагдвал гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авна.

8.3. Эрүүл мэндийн байгууллага нь гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг бууруулснаас үүдэн иргэнээс нэмэлт төлбөр авах, төлбөртэй үзүүлэх, өөр эрүүл мэндийн байгууллага руу шилжүүлсэн тохиолдолд торгууль ногдуулах, уг тусламж, үйлчилгээний хувьд гэрээ цуцлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцон, ЭМДС-аас санхүүжүүлэхэд дараах зохицуулалтыг баримтална.

Тусламж, үйлчилгээний төрөл	Нэгж тохиолдлыг тооцох	Тохиолдлын тоог хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдолд хамаарах зардлын бүрэлдэхүүн
1. Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ			
1.1. Амбулаторийн тусламж, үйлчилгээ /Өвчний учир үзлэг/	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас амбулаторийн эмчийн (Чих хамар хоолой, нүд, эмэгтэйчүүд г.м) үзлэгийг нэг тохиолдолд тооцож санхүүжүүлнэ.		Амбулаторийн үзлэгийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн нэг удаагийн үзлэг, зөвлөгөө, түүнд шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.
1.2. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн эмчийн үзлэг, шаардлагатай оношилгоо, шинжилгээ бүхий амбулаторийн тусламж, үйлчилгээг амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний нэг тохиолдолд тооцож санхүүжүүлнэ.	1.Нарийн мэргэшлийн эмч нь иргэн, даатгуулагчийн оношийг тогтоох зорилгоор оношилгоо, шинжилгээ болон эмчийн үзлэгийг удаа дараа давтан хийсэн нь “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багц”-ын тохиолдлын тоог нэмэх үндэслэл болохгүй. 2. Оношилгоо, шинжилгээ хийгдээгүй, амбулаторийн үзлэгийн тохиолдлуудыг “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багц”-д тооцохгүй.	Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд тухайн иргэний амбулаторид хандсан шалтгааныг тодруулж, өвчний онош тогтоох зорилгоор хийгдсэн бүх төрлийн эмчийн үзлэгүүд, зөвлөгөө, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, онош тогтоох, тодруулах зорилгоор хийсэн бүх оношилгоо тухайлбал дуран, компьютер болон соронзон резонанст томографын оношилгоо, тодосгогч бодис, бүх төрлийн лабораторийн шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	1. Даатгуулагч нь өвчний учир, эмчийн заалтаар тухайн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багц авсан тохиолдолд дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд: 1.1. Даатгуулагчийн оношийг тодруулах зорилгоор нэг буюу хэд хэдэн нарийн мэргэшлийн эмчийн үзлэг, холбогдох оношилгоо, шинжилгээнд хамруулж болно. Хэрэв цогц тусламж, үйлчилгээний хүрээнд даатгуулагчид хоёр ба түүнээс дээш өвчний онош тодорхойлогдсон тохиолдолд баталгаажсан үндсэн оношид хамаарах ОХБ-ээр санхүүжүүлнэ. Нэхэмжлэлд хавсарсан онош, эмчийн үзлэгийн тэмдэглэлд багцын хүрээнд хийгдсэн оношилгоо, шинжилгээний үр дүнг тусгах бөгөөд түлхүүр үзүүлэлтийг хангасан эсэхийг хянасан чанар, төлбөрийн хяналтын үр дүнд үндэслэн санхүүжүүлнэ.	

		<p>1.2. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцыг эмчийн үзлэгээр дуусгавар болгохыг дэмжих бөгөөд тухайн багцын хүрээнд гаргасан зардлаас нь хамааруулан нэгж тохиолдлыг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:</p> <p>1.2.1. Хэрэв амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц нь эмчийн үзлэгээр дуусгавар болсон бөгөөд тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 71 ба түүнээс дээш хувьтай тэнцэхүйц тохиолдолд багцын тарифаар буюу бүтэн санхүүжилтийг олгоно.</p> <p>1.2.2. Хэрэв амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц нь эмчийн үзлэгээр дуусгавар болсон бөгөөд тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 70 ба түүнээс доош хувьтай тэнцэхүйц тохиолдолд гарсан бодит зардлын дүнгээр санхүүжүүлнэ.</p> <p>1.2.3. Хэрэв амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц нь эмчийн үзлэгээр дуусгавар болоогүй бөгөөд тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 70 ба түүнээс дээш хувьтай тэнцэхүйц тохиолдолд тухайн багцын тарифын 70 хувьтай тэнцэхүйц дүнгээр санхүүжүүлнэ.</p> <p>1.2.4. Хэрэв амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээний багц нь эмчийн үзлэгээр дуусгавар болоогүй бөгөөд тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 70-иас доош хувьтай тэнцэхүйц тохиолдолд гарсан зардлын дүнг 10 хувиар бууруулж санхүүжүүлнэ.</p> <p>1.3. Эрхтэн шилжүүлэн суулгахын өмнөх амбулаторийн цогц тусламж үйлчилгээг 6 хүртэлх удаа нэхэмжлэх боломжтой бөгөөд эмнэлзүйн удирдамжийн дагуу реципиент болон донорт хийгдэх шаардлагатай оношилгоо, шинжилгээг тус бүрээр санхүүжүүлэх бөгөөд оношилгоо, шинжилгээг бүрэн хийсэн эсэхийг чанар төлбөрийн хяналтыг үндэслэн санхүүжүүлнэ.</p> <p>2. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-д орсон нэгжийн үнэ нь 45000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй оношилгоо шинжилгээг² амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцын хүрээнд хийсэн тохиолдолд уг оношилгоо, шинжилгээнд 30 хувийн хамтын төлбөр төлөх бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг энэхүү журмын 5 дугаар бүлэгт зохицуулсан “Иргэний төлөх төлбөр” хэсэгт зохицуулна.</p> <p>3. “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багц” авч байх хугацаанд “Мэс заслын эмчилгээний дараах хяналт”, “Амбулаториор хийгдэх оношилгоо”, жирэмсэний хяналт -ний багцыг давхардуулан нэхэмжлэх боломжтой бөгөөд амбулаторийн бусад тусламж, үйлчилгээг давхардуулан нэхэмжлэл үүсгэхгүй.</p> <p>4. Эрүүл мэндийн байгууллага нь даатгуулагчийн оношийг тодруулах зорилгоор хуанлийн 30 хоногийн дотор өөр эрүүл мэндийн байгууллага руу өвчтөн шилжүүлэх журмын дагуу ижил ОХБ-ээр нэг удаа илгээж болох бөгөөд энэ тохиолдолд эмнэлэг тус бүрд “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ”-ний холбогдох ОХБ-ийн санхүүжилтийг цогц тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлснээс нь хамааран журмын дагуу олгоно.</p> <p>5. Эрхтэн шилжүүлэн суулгахын өмнөх амбулаторийн цогц тусламж, үйлчилгээг донорт хийсэн тохиолдолд реципиентийн регистрийн дугаарыг хамтад нь авна.</p> <p>6. Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник нь хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас өөрийн үйлчлүүлэгчид хийх шаардлагатай өндөр өртөг бүхий шинжилгээг өөр эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд оношилгоо, шинжилгээний төлбөрийг ЭМДЕГ-тай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх бөгөөд тухайн эмнэлэг нь төлбөр тооцоогоо эмнэлэг хоорондын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэнэ.</p> <p>7. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцыг дуусгавар болгож буй эмч нь багцын үр дүнгээс хамаарч дараах сонголтыг системд бүртгэнэ. Үүнд:</p> <p>7.1. Өвчний оношийг баталгаажуулж, анхан шатны ЭМБ руу шилжүүлсэн.</p> <p>7.2. Өвчний оношийг баталгаажуулж, хэвтүүлэн эмчлэх болон бусад тусламж, үйлчилгээ рүү илгээсэн.</p> <p>7.3. Өвчний онош нь баталгаажаагүй бөгөөд өөр ЭМБ руу шилжүүлсэн.</p>
--	--	--

<p>1.3. Амбулаториор хийгдэх мэс ажилбар</p>	<p>Амбулаторийн нөхцөлд хэсгийн мэдээгүйжүүлгийн дор богино хугацаанд /90 хүртэлх минут/ оношилгоо, эмчилгээний зорилгоор хийсэн ажилбар эсхүл мэс ажилбар хийсэн тохиолдлыг амбулаториор хийгдэх ажилбарт тооцно. Даатгуулагчийн хийлгэсэн “Амбулаториор хийгдэх мэс ажилбар” бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож санхүүжүүлнэ.</p>	<p>Ажилбар хийсний дараах үр дүнг хянах зорилгоор давтан хийгдэж эмчийн үзлэг боолт нь тухайн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоог нэмэх үндэслэл болохгүй.</p>	<p>Амбулаториор хийгдэх ажилбарын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, мэс ажилбар, шархны цэгцэлгээ, боолт, эмчилгээ, сувилгаа, нэг удаагийн хэрэгсэл болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>1.4. Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ</p>	<p>Даатгуулагч өвчний учир сумын эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, төрийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт үзүүлэн шүдний цогц тусламж, үйлчилгээ авсан тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно. Даатгуулагчийн нэг шүдийг бүрэн эмчлэх бүхий л тусламж, үйлчилгээг цогц тусламж, үйлчилгээ хэмээн үзнэ.</p>	<p>Нүүр, ам судлалын эмч нь даатгуулагчийн шүд, амны хөндийн цогц тусламжийг үзүүлэхээр нэг шүдэнд давтан эмчилгээ хийх, улмаар давтан үзлэгийг удаа дараа хийсэн нь “Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээний багц”-ын тохиолдлын тоог нэмэх үндэслэл болохгүй.</p>	<p>Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд шүд, амны хөндийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, тухайн шүдний бүрэн эмчилгээ болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн даатгалын сангаас жилд 0-6 насны хүүхдийн нийт 5 хүртэлх, 7-18 насны хүүхдийн 6 хүртэлх шүдний цогц тусламж үйлчилгээг санхүүжүүлэх бөгөөд жирэмсний хяналтад буй эмэгтэйд үзүүлсэн шүд амны хөндийн тусламж, үйлчилгээний хувьд эмчилсэн шүдний тоо хэмжээг хязгаарлахгүй санхүүжүүлнэ. Нэг шүдийг давтан эмчилсэн тохиолдлыг давхардуулан санхүүжүүлэхгүй. 2. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлж эмчилсний дараа нэхэмжлэл илгээх ба нэхэмжлэлд эмчилгээ хийсэн шүдний дугаарыг тавина. 3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын чадамжид үндэслэн энэхүү оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх бөгөөд дараах зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 3.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь чадамж бүхий хувийн хэвшлийн шүд амны хөндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг клиниктэй гэрээлэх замаар тусламж, үйлчилгээ үзүүлж болох бөгөөд үзүүлсэн тусламжийн чанарт тогтмол хяналт хийн ажиллана. 3.2. Сумын эрүүл мэндийн төвд даатгуулагчийн шүдний сурвалжийн сувгийн эмчилгээ хийсэн тохиолдолд ОХБ-ын төлбөрийг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно. 	
<p>1.5. Хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх</p>	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас 0-6 насны хүүхдэд үзүүлсэн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний тохиолдол тус бүрийг нэгж тохиолдол гэж тооцно.</p>	<p>7-оос дээш насны байнгын шүдний урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ хамаарахгүй болно.</p>	<p>Хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд шүд, амны хөндийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө, хамгаалах болон фторт түрхлэгийн зардал хамаарна.</p>

<p>тусламж, үйлчилгээ</p>	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт баримтлах</p>	<p>1. Хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний зардлыг нэг хүүхдэд жилд 2 хүртэлх тохиолдлыг санхүүжүүлнэ. Нэг хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний 2 удаагийн тохиолдлын хооронд дор хаяж 5 сарын зайтай байгаа тохиолдолд жилд 2 тохиолдлыг санхүүжүүлнэ.</p> <p>2. Даатгалын байгууллагаас чадамжид (хүний нөөцийн хувьд мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх) суурилсан үнэлгээг газар дээр нь хийж гэрээлж, санхүүжүүлнэ. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь тухайн сум, тосгон, аймагт байршилтай, байнгын үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй гэрээлэх замаар тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой.</p> <p>3. Чадамж бүхий эрүүл мэндийн байгууллагад 6 настай хүүхдийн араа шүдийг хамгаалах зорилгоор силант түрхэх үйлчилгээг энэхүү багцаар нэхэмжилж болно.</p>
<p>1.6. Амбулаторийн хяналтын үзлэг</p>	<p>1. Эмчийн заалтаар хийгдэж буй “Амбулаторийн хяналтын үзлэг” бүрийг нэг тохиолдол хэмээн тооцно.</p> <p>2. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах амбулаторийн хяналтын үзлэгийн багцаар донор болон реципиентын хяналтын үзлэгийг тус тусад нь нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Санхүүжүүлэхэд зохицуулалт баримтлах</p>	<p>Байнгын хяналт шаардлагагүй, нэг удаагийн шинжтэй хяналтыг амбулаторийн хяналтын үзлэгээр нэхэмжлэхийг хориглоно.</p> <p>Амбулаторийн хяналтын үзлэгийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилагчийн гардан үйлдэл, тухайн хяналтын өвчтний өвчний явцыг хянах, тодруулах зорилгоор хийгдсэн бүх төрлийн оношилгоо тухайлбал дуран, компьютер болон соронзон резонанст томографийн оношилгоо, тодосгогч бодис, бүх төрлийн лабораторийн шинжилгээний зардал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл болон холбогдох бусад зардал хамаарна.</p> <p>Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиник болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн “Амбулаторийн хяналт”-ын бүртгэлд бүртгэгдсэн даатгуулагчид үзүүлсэн амбулаторийн байнгын хяналтын үзлэгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тохиолдлоор санхүүжүүлнэ.</p> <p>1. Даатгуулагч нь эмчийн заалтаар тухайн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад амбулаторийн хяналтын үзлэгийн багц авсан тохиолдолд тухайн багцын хүрээнд гаргасан зардлаас нь хамааруулан нэгж тохиолдлыг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:</p> <p>1.1. Тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 70-иас дээш хувьтай тэнцэхүйц тохиолдолд багцын тарифаар буюу бүтэн санхүүжилтийг олгоно.</p> <p>1.2. Тухайн тохиолдлын нийт зардал нь нэхэмжилж буй багцын тарифын 70 ба түүнээс доош хувьтай тэнцэхүйц тохиолдолд гарсан бодит зардлын дүнгээр санхүүжүүлнэ.</p> <p>1.3. Хэрэв эмчийн дан үзлэг хийгдсэн тохиолдолд амбулаторийн хяналтын үзлэгийн багцаар нэхэмжлэхгүй, санхүүжүүлэхгүй.</p> <p>2. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-д орсон нэгжийн үнэ нь 45000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй оношилгоо шинжилгээг² амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцын хүрээнд хийсэн тохиолдолд уг оношилгоо, шинжилгээнд 30 хувийн хамтын төлбөр төлөх бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг энэхүү журмын 5 дугаар бүлэгт зохицуулсан “Иргэний төлөх төлбөр” хэсэгт зохицуулна.</p> <p>3. Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиник болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмчийн хяналтад зайлшгүй байх шаардлагатай иргэнийг “Амбулаторийн хяналт”-ын бүртгэлийн системд бүртгэх бөгөөд бүртгэлд хяналтад орж буй онош, шалтгаан, хяналтад авч буй хугацаа, хяналт хийх давтамжийг заавал оруулна.</p> <p>4. Эрүүл мэндийн байгууллага нь хяналтад буй тухайн даатгуулагчийн дараагийн хяналтад ирэх үзлэгийн болон шинжилгээний хугацааг урьдчилан захиалах, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлсэн байна.</p> <p>5. “Эрхтэн шилжүүлэх мэс засал”-ын дараа “Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах хяналт”-ын багцаар тусламж, үйлчилгээ авах, нэхэмжлэх эрх үүснэ. Гадаадын улс оронд эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал</p>

		<p>хийлгэсэн даатгуулагчийн хяналтыг энэхүү оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэх ба тухайн даатгуулагчийн мэдээллийг илгээнэ.</p> <p>6. Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник нь хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас өөрийн үйлчлүүлэгчид хийх шаардлагатай өндөр өртөг бүхий шинжилгээг өөр эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд оношилгоо, шинжилгээний төлбөрийг ЭМДЕГ-тай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх бөгөөд тухайн эмнэлэг нь төлбөр тооцоогоо эмнэлэг хоорондын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэнэ.</p> <p>7. Амбулаторийн хяналтын үзлэгийн дараа төрөөс төлбөрийг нь хариуцах зарим эмийг энэ тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу тохиолдол бүрээр тооцож олгоно.</p> <p>8. Амбулаторийн хяналтын үзлэгийн дараа нарийн мэргэшлийн эмч “Төрөөс төлбөрийг нь хариуцах зарим өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт, хэлбэр, тун”-д заасан өвчин, эмгэгийн үед хэрэглэх эмийн жорыг бичих эрх нээгдэнэ.</p>
<p>1.7. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ</p>	<p>Иргэн, даатгуулагчийн жирэмсний хяналтыг гардан хийж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан журамд заасан лавлагаа шатлалын хяналтын үзлэгийг хийлгэх зорилгоор лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага руу, эсхүл жирэмсний хяналт хийж буй лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг рүү илгээх бичгээр илгээсэн тохиолдлыг жирэмсний хяналтын нэгж тохиолдолд тооцно.</p>	<p>1. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо нь Эрүүл мэндийн сайд (ЭМС)-ын жирэмсний хяналтыг зохицуулсан холбогдох тушаалаар баталсан жирэмсэн эхийг лавлагаа шатлалд хянах товлолын тоогоор хязгаарлагдана.</p> <p>2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь жирэмсний хяналтыг холбогдох журмын дагуу хийх бөгөөд үүнтэй холбогдох зардал нь энэхүү журмаар зохицуулагдахгүй.</p> <p>Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн анхан болон оношилгоо, шинжилгээний дараах үзлэг, зөвлөгөө, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, онош тодруулах зорилгоор хийсэн бүх төрлийн оношилгоо, шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>1. Эрүүл мэндийн байгууллага нь жирэмсэн эмэгтэйг уг товлолоос өөр хугацаанд өвчний учир үзлэгт хамруулсан тохиолдолд “Амбулаторийн үзлэг” эсхүл “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багц”-аар нэхэмжилнэ.</p> <p>2. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээнээс эмчийн заалтаар тухайн лавлагаа шатлалын нэг эрүүл мэндийн байгууллагад амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцыг авч болно.</p> <p>3. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлсэн эсэхээс хамааран төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:</p> <p>3.1. Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн жирэмсний хяналтын анхан болон оношилгоо, шинжилгээний дараах үзлэгийг, холбогдох оношилгоо шинжилгээний хамт цогц байдлаар үзүүлсэн тохиолдлыг “Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ”-ний нэг тохиолдол гэж тооцон, жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр буюу 100 хувь санхүүжүүлнэ.</p> <p>3.2. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээнд хамаарах оношилгоо, шинжилгээ хийгдээгүй, жирэмсний хяналтын дан үзлэгийг өвчний учир амбулаторийн эмчийн үзлэгийн (51300020 код бүхий) ОХБ-ийн төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ.</p> <p>4. Даатгуулагч жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ авсны дараа тухайн хяналтын эмчийн илгээлтээр жирэмсэнтэй холбогдох шалтгаанаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг аль алиныг нь 100 хувиар тооцон санхүүжүүлнэ.</p>

		<p>5. Жирэмсний 12 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээг жирэмсний 2-12 дугаар долоо хоногт хийсэн тохиолдолд, бусад жирэмсний хяналтын үе шатанд хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээг товллын хугацаанаас +6,-6 хоногт хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ. Уг зөвшөөрөгдсөн хугацаанаас өөр хугацаанд хийсэн жирэмсний хяналтын үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлыг санхүүжүүлэхгүй.</p> <p>6. Анх удаа жирэмсний хяналтад орж байгаа тохиолдолд эхний удаагийн хяналтын үзлэгт товллолт хугацаа шаардахгүйгээр санхүүжүүлэх бөгөөд дараагийн давтан хяналтын үзлэгээс эхлэн товллолт хугацаанд хяналтад орсон тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p> <p>7. Жирэмсний хяналтад Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан холбогдох тушаал шийдвэрийг мөрдөх бөгөөд энэхүү журам нь зөвхөн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх жирэмсний хяналтын үзлэгийг санхүүжүүлэхэд мөрдөгдөнө.</p> <p>8. Жирэмсний хяналтын анхны товллолт буюу 12 дугаар долоо хоног хүртэл болон 32 долоо хоногийн товллолын үзлэг дээр шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан оношилгоо, шинжилгээг бүрэн хийсэн тохиолдолд төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж санхүүжүүлнэ. Хэрэв бүрэн хийгээгүй тохиолдолд нэмэгдүүлсэн төлбөрийн хэмжээнээс Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр хасаж санхүүжүүлнэ.</p>
<p>1.8.Нийт амбулаторийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд баримтлах нийтлэг зохицуулалт</p>		<p>1. Амбулаторийн үзлэгийг утсаар болон зайнаас үзүүлсэн бол амбулаторийн үзлэгийн тохиолдолд тооцохгүй, санхүүжүүлэхгүй.</p> <p>2. Амбулаторийн тусламж, үйлчилгээний дараа “Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох” эмийн жор бичих эрх үүсэх бөгөөд шаардлагатай тохиолдолд жорыг заавал бичнэ.</p> <p>3. Амбулаторийн үзлэгийн нэг өвчтөнд зарцуулах анхан болон давтан үзлэгийн дундаж хугацаа тус бүр 10 минутаас доошгүй байна.</p> <p>4. Эмчийн амбулаторийн үзлэгийн анамнез, бодит үзлэгийн тэмдэглэлд оношийн үндэслэлд хамаарах голлох өөрчлөлтийг тусгах ба энэ нь 300 тэмдэгтээс доошгүй байна.</p>
<p>2.Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбар</p>		
<p>2.1. Амбулатор - иор хийгдэх оношилгоо, ажилбар</p>	<p>Даатгуулагчийн тухайн сард эмчийн заалтаар лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад нэг оношийн хүрээнд хийлгэсэн ижил төрлийн оношилгоо, шинжилгээний тохиолдлуудыг багцлан нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>1. Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын багцын зардлын бүрэлдэхүүнд эмчийн дүгнэлт, урвалж, бодис, лабораторийн зардал, техникч болон лаборантын цалин, засвар, үйлчилгээ болон холбогдох бусад зардал хамаарна.</p> <p>2. Эмгэг судлалын шинжилгээний зардлын бүрэлдэхүүнд эмгэг судлалын шинжилгээ хийхэд зарцуулагдах бүх оношлуур, хэрэгсэл, эмгэг шинжилгээний дүгнэлт бичих зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>2.1.Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>		<p>1. Эрүүл мэндийн даатгалын сангаас амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын нэг тохиолдлыг санхүүжүүлэхдээ ОХБ-ийн жагсаалтад батлагдсан холбогдох оношилгоо, шинжилгээний төлбөрийн хэмжээг баримтална.</p> <p>2. Эмгэг судлалын шинжилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс тусад нь нэхэмжлэх ба эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхдээ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”-г баримтална. ЭМДЕГ-ын даргын тушаалаар жагсаалтыг батална.</p> <p>3. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь бусад эмнэлэг хийсэн оношилгоог зайлшгүй тохиолдолд давтан хийсэн тохиолдолд давтан оношилгоог ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үр дүнд үндэслэн хэрхэн санхүүжүүлэхийг шийдвэрлэнэ.</p>

	<p>4. ЭМДЕГ нь нэг даатгуулагчид тухайн сардаа ижил төрлийн оношилгоог 2 ба түүнээс дээш тохиолдлыг хийсэн нэхэмжлэл хүлээн авсан тохиолдолд ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үр дүнд үндэслэн хэрхэн санхүүжүүлэхийг шийдвэрлэнэ.</p> <p>5. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэг хийсэн эмчийн заалтаар хийсэн өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээний тохиолдол бүрийг ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас тухайн өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээг тухайн даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эсэх болон бусад төрлийн хяналт хийсний үндсэн дээр санхүүжүүлнэ.</p> <p>6. Эмгэг судлалын шинжилгээг эмгэг судлалын нэгжтэй бол тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө, эмгэг судлалын нэгжгүй бол сорьцоо Эмгэг судлалын үндэсний төвд илгээх бөгөөд шинжилгээг хийж дууссаны дараа Эмгэг судлалын төв нь Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас шинжилгээний төлбөрийг нэхэмжилнэ. Тухайн шинжилгээний нэхэмжлэлийг илгээхэд иргэний танин баталгаажуулалт шаардахгүй.</p> <p>7. ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар тухайн эрүүл мэндийн байгууллага нь иргэнд шаардлагагүй тохиолдолд өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ хийсэн нь тогтоогдвол уг тохиолдлын зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллага нь иргэнээс авсан иргэний хариуцан төлсөн төлбөрийг 100 хувь буцаан олгоно.</p> <p>8. Амбулаторийн тусламж, үйлчилгээний багцад нийтлэг ашиглагддаггүй зарим төрлийн өвөрмөц шинжилгээг 51300047 дугаартай оношийн хамааралтай бүлгийн хүрээнд “Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ын жишиг төлбөрийн хэмжээг баримтлан ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан холбогдох эмнэлзүйн удирдамжийн дагуу хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ.</p> <p>9. А) Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээ Б) амбулаторийн хяналтын үзлэг хийснээс 14 хоногийн дотор тухайн үзлэг хийсэн оношийн хүрээнд хийгдсэн оношилгоог Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p>	
<p>2.3.Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын холбогдох бусад зохицуулалт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарыг тухайн оношийн хүрээнд хийгдэх ерөнхий оношилгоо, шинжилгээгээр онош нь тодрох боломжгүй, нарийн оношилгоо хийлгэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвхөн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмчийн заалтаар хийнэ. 2. Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник нь хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас өөрийн үйлчлүүлэгчид хийх шаардлагатай өндөр өртөг бүхий шинжилгээг өөр эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд оношилгоо, шинжилгээний төлбөрийг ЭМДЕГ үндсэн үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад нэгдсэн эмнэлэг, клиникт шилжүүлэх бөгөөд эмнэлгүүд төлбөр тооцоогоо эмнэлэг хоорондын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэнэ. 3. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний явцад тухайн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас иргэнийг өндөр өртөг бүхий оношилгоо шинжилгээ хийлгэхээр өөр эрүүл мэндийн байгууллага руу илгээсэн тохиолдолд төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллага бүрэн хариуцаж, оношилгоо шинжилгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагад, эсхүл даатгуулагчид төлбөрийн баримтыг үндэслэн төлнө. 4. А) Амбулаторийн цогц, тусламж, үйлчилгээ Б) амбулаторийн хяналт В) амбулаториор хийгдэх ажилбар Г) хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ Д) өдрийн мэс заслын үед болон 14 хоногийн дотор эмгэг судлалын шинжилгээ хийх эрх үүснэ. 	<p>3. Өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ</p>
<p>3.1. Өдрөөр хийх хорт хавдрын системийн химийн эмчилгээ</p>	<p>Өдрөөр хийх хорт хавдрын системийн химийн эмчилгээг хийсэн тохиолдол нэг бүрийг нэгж тохиолдол хэмээн тооцно.</p>	<p>Өдрөөр хийх хорт хавдрын системийн химийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх химийн тариа, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>3.2 Өдрөөр хийх хорт</p>	<p>Өдрөөр хийх хорт хавдрын химийн бай эмчилгээг хийсэн эмчилгээ</p>	<p>Өдрөөр хийх химийн бай эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх химийн бай</p>

хавдрын химийн бай эмчилгээ	(химийн бай эмчилгээний эмээс бусад) нэг бүрийг нэгж тохиолдол хэмээн тооцно.		эмчилгээний эмээс бусад эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
3.3. Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт		1. Жагсаалтад багтаагүй химийн бай эмчилгээний эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй. 2. Тухайн багцын хувьд системийн химийн эмчилгээг хавсран хийсэн тохиолдолд бай эмчилгээний ОХБ-ээр санхүүжүүлэхгүй бөгөөд бай эмчилгээний эмийг нэмэлтээр санхүүжүүлнэ.	
3.4. Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ	Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээнд авсан удаа бүрийг нэг тохиолдол гэж тооцож нийт туяа эмчилгээнд орсон хоногийн тоогоор үржүүлж санхүүжүүлнэ.		Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, тусламж, үйлчилгээ үзүүлж буй үед ашиглагдах туяа эмчилгээний эм тариа, унтуулгын эм, эмнэлгийн хэрэгслийн зардал, сувилахуйн зардал, туяа эмчилгээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
3.5. Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт		1. Хэрэв тухайн даатгуулагчид хорт хавдрын туяа болон химийн өдрийн эмчилгээг нэгэн зэрэг хавсран хийсэн тохиолдолд 2 эмчилгээг тус бүрд нь санхүүжүүлнэ. 2. Даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэх үед зайлшгүй шаардлагаар хорт хавдрын туяа эмчилгээ хийсэн тохиолдолд хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардал болон хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээний зардлыг холбогдох туяа эмчилгээний төлбөрийн хэмжээг баримтлан тохиолдлын тоогоор нэмж санхүүжүүлнэ. 3. Үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг илгээхдээ хийгдсэн хими болон туяа эмчилгээг Z оношоор, үндсэн хавдрын оношийг хамтад нь заавал бүртгэж илгээнэ. 4. Химийн эмчилгээнд уух хэлбэрээр хэрэглэдэг эмийг нэг сарын эмчилгээний эмийг даатгуулагчид бүрэн олгоно. 5. Өдрөөр хийх хорт хавдрын бай эмчилгээг санхүүжүүлэхдээ 1) өдрөөр хийх хорт хавдрын химийн бай эмчилгээ (эмээс бусад тусламж үйлчилгээ) болон 2) бай эмчилгээнд ашигласан эмийн зардлын нийлбэрээр санхүүжүүлэх бөгөөд эдгээр тусламж, үйлчилгээнүүдийн нэхэмжлэлийг тусад нь илгээнэ. 6. Өдрөөр хийх хорт хавдрын бай эмчилгээний эмийн зардлыг энэхүү тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан журмын дагуу 5 дугаар хавсралтад заасан жагсаалтад багтсан эмийн зардлыг олгох бөгөөд зөвхөн тухайн химийн бай эмчилгээнд ашиглагдсан тун, хэмжээнд чанар, төлбөрийн хяналт хийж, санхүүжүүлнэ. 7. Өдрөөр хийх хорт хавдрын системийн химийн эмчилгээ болон бай эмчилгээг хавсран хийсэн тохиолдолд өдрөөр хийх хорт хавдрын системийн химийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгээр нэхэмжилж, санхүүжүүлнэ.	
3.6. Диализын тусламж, үйлчилгээ	Диализын эмчилгээ тус бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.		Диализын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, диализын шингэн, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо шинжилгээ, сувилахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт		1. Даатгуулагч нь хэвтүүлэн эмчлэх эмийн тусламж, үйлчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээ авах хугацаанд диализ эмчилгээнд хамрагдсан тохиолдолд диализын эмчилгээний зардлыг нь диализ эмчилгээний төлбөрийн хэмжээг баримтлан тохиолдлын тоогоор тооцож, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардал дээр нэмж олгоно. 2. Өдрөөр хийлгэх диализ болон диализын тусламж, үйлчилгээний хяналтаас өөр, цаг товлосон амбулаторийн үзлэгийг холбогдох оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр тусад нь санхүүжүүлнэ.	

3.7. Өдрийн эмийн эмчилгээ	Өдрийн эмийн эмчилгээ нь нэг оношоор 5-аас доошгүй хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нэг багц гэж тооцно.	Өдрийн эмийн эмчилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг давхардуулан санхүүжүүлэхгүй	Өдрийн эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, сэргээн засах эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд захицуулалт	баримтлах	1. Даатгуулагчид өдрийн эмийн эмчилгээ үзүүлж байх хугацаанд тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцож санхүүжүүлнэ. 2. Тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан 51340035 код бүхий оношийн хамааралтай бүлгийн Иод 131 эмчилгээнд өвчний түүх нээж 5 хоног эмчлэх шаардлагагүй тул тухайн тусламж, үйлчилгээг холбогдох эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу үзүүлсэн эсэхэд хяналт тавьж санхүүжилтийг олгоно.
3.8. Өдрийн мэс засал	Эрүүл мэндийн байгууллагад мэс засал хийлгэж, тухайн өдрөө эмнэлгээс гарсан буюу 24 цагийн дотор мэс заслын тусламж авч эмнэлгээс гарсан тохиолдлыг өдрийн мэс заслын нэг тохиолдолд тооцно.	Өдрийн мэс засал, хэвтүүлэн эмчлэх мэс заслыг давхардуулан санхүүжүүлэхгүй	Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, мэс засал, мэс ажилбар, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, (өндөр үнэ бүхий болон бусад), ороох боох материал, сэргээн засах эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд захицуулалт	баримтлах	Даатгуулагчид өдрийн мэс засал хийсний дараа эмнэлзүйн шаардлагаар эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн тухайн мэс засал хийлгэсэн оношийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ.
4. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ			
4.1. Эрчимт эмчилгээ	1. Даатгуулагч нь эрхтэн системийн дутагдалд орж эмчийн заалтаар, зайлшгүй шаардлагаар эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлсэн сэргэх боломжтой тохиолдол тус бүрийг эрчимт эмчилгээний нэг тохиолдол гэж тооцно.	1. Судсан дотуур хийх (ангиографийн) мэс заслын дараа хяналт хийх зорилгоор иргэнийг эрчимт эмчилгээний тасагт богино хугацаагаар хянасан тохиолдлыг эрчимт эмчилгээний тохиолдолд тооцохгүй. 2. Мэс засал эмчилгээний дараах сэрээх ерөөний хяналтыг эрчимт эмчилгээний тохиолдолд тооцохгүй. 3. Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг нэхэмжлэхдээ зарцуулсан бодит зардлаас өндөр тариф бүхий ангиллаар нэхэмжилсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар тогтоогдсон болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.	Эрчимт эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, эрхтэн орлуулах эмчилгээ, ажилбар, цус цусан бүтээгдэхүүн, эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээний зардал, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд захицуулалт	баримтлах	1. Даатгуулагч эмнэлэгт эмчлүүлэх хугацаандаа эрчимт эмчилгээний тасгаар удаа дараа үйлчлүүлсэн нь тохиолдлын тоог нэмэгдүүлэх үндэслэл болохгүй бөгөөд дор дурдсанаар санхүүжүүлнэ. Үүнд: 1.1. Иргэн яаралтай тусламжийн тасгаас эрчимт эмчилгээний тасаг руу шууд шилжиж, эрчимт эмчилгээний тасагт өвчний түүх нь хаагдсан тохиолдолд зөвхөн эрчимт эмчилгээг нэг тохиолдол гэж тооцон санхүүжүүлнэ. /зөвхөн эрчимт эмчилгээний 1 тохиолдолд/

- 1.2. Иргэн яаралтай тусламжийн тасгаас эрчимт эмчилгээний тасаг руу, эрчимт эмчилгээний тасгаас хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тасагт шилжиж эмийн эмчилгээний тусламж авсан тохиолдолд эрчимт эмчилгээний 1 тохиолдол болон эмийн эмчилгээний холбогдох оношийн хамааралтай бүлгийн /ОХБ/ 1 тохиолдол гэж тус тус тооцон санхүүжүүлнэ. /эрчимт эмчилгээ + эмийн эмчилгээ/
- 1.3. Иргэн яаралтай тусламжийн тасгаас эрчимт эмчилгээний тасаг руу, эрчимт эмчилгээний тасгаас мэс заслын тасаг руу шилжиж тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд эрчимт эмчилгээний 1 тохиолдол болон мэс заслын тусламж, үйлчилгээний холбогдох ОХБ-ийн нэгж тохиолдол гэж тус тус тооцон санхүүжүүлнэ. /эрчимт эмчилгээ + мэс засал/
- 1.4. Иргэн тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаандаа эрчимт эмчилгээний тасаг руу удаа дараа шилжсэн нь эрчимт эмчилгээний тохиолдлын тоог нэмэгдүүлэх үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн нэг удаагийн эрчимт эмчилгээний зардлыг санхүүжүүлнэ.
4. Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг эрчимт эмчилгээний тасагт үзүүлсэн тусламж, үйлчилгээнд зарцуулсан зардалд үндэслэн эрчимт эмчилгээний А, В, С, D бүлгээр санхүүжүүлэх бөгөөд бүлэг тус бүрээр дараах хүснэгтээр тодорхойлсон тусламж, үйлчилгээг зайлшгүй үзүүлсэн байна.

№	Авсан арга хэмжээ	Бүлэг			
		A	B	C	D
1	Эмийн эмчилгээ	*	*	*	*
2	Сувилахуйн тусламж болон хяналт	*	*	*	*
3	Эмчийн үзлэг, хяналт	*	*	*	*
4	Лабораторийн суурь шинжилгээ /Жишээ нь: ЦЕШ, ШЕГ, биохимийн шинжилгээ, цусны бүлэгнэлт/, багажийн оношилгоо /Жишээ нь: Рентген,хэт авиа, ЗЦБ,/ Төв венийн гуурс хийх Гемодиализын гуурс хийх Давсагны гуурсны ажилбар Интубацийн гуурс хийх Ходоодонд зонд тавих ажилбар Артерийн судсанд гуурс байрлуулах Цээжний хөндийд гуурс хийх /ТВГ/ Цээжний хөндийд гуурс хийх – Самбартай Нугасны хөндийд хатгалт хийх Хэвлийн хөндийд хатгалт хийх, гуурс байрлуулах Үнхэлцгийн хөндийд хатгалт хийх, гуурс байрлуулах Цахилгаан кардиоверси Бронхоскопи, бронхосанацци хийх Трахейстомын гуурс хийх Цистостомийн гуурс хийх Блэйкморын зонд байрлуулах Гемодиализ эмчилгээ хийх	*	*	*	*
5	Шаардлагатай ажилбарыг хийсэн байх	*	*	*	*

6	Оношилгоо, шинжилгээ / MRI, CT, уян дуран, эрчимт эмчилгээнд шаардагдах лабораторийн шинжилгээ*	*	*		
7	Ахисан түвшний ажилбар / Гавлын дотоод даралт хянах гуурс/, эрхтэн орлуулах эмчилгээг /зохиомол амьсгал г.м/ хийсэн байх	*			

5. Дээрх хүснэгт дэх оношилгоо, шинжилгээ, ажилбарыг эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэх хугацаанд хийгдсэн тохиолдлыг тооцох ба өөр тасагт эмчлэгдэж байх хугацаанд хийгдсэнийг бүрдэлд тооцохгүй.
6. Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн нэхэмжилсэн ОХБ-ийн ангиллын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан зардлын бүрдэлд чанар, төлбөрийн хяналт хийж, санхүүжүүлнэ. Хэрэв бүрдэлд заасан тусламж, үйлчилгээг дутуу үзүүлсэн тохиолдолд уг нэхэмжлэлийг санхүүжүүлэхгүй.
7. Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн нь тухайн эмнэлзүйн тохиолдол, нас, хүйсээс хамаарч харилцан адилгүй байх бөгөөд доорх шинжилгээнээс шаардлагатай шинжилгээг хийсэн байна.

№	Эрчимт эмчилгээнд шаардагдах лабораторийн шинжилгээний нэр*	№	Эрчимт эмчилгээнд шаардагдах лабораторийн нэр*
1	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	15	Кортизол (Cortisol)
2	Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	16	Прокалцитонин (Procalcitonin)
3	Миоглобин	17	Тропонин I (Troponin I)
4	Креатинфосфокиназа МВ	18	Тропонин Т (Troponin T)
5	NH3/аммони/	19	Цитомегаловирус (CMV antigenemia)
6	АТ III	20	Цусны ийлдэст IgM/IgG илрүүлэх
7	Цистатин С	21	Clostridium difficile toxin A,B
8	ToRCH вирусийн шинжилгээ	22	D-Dimer
9	Миелограмм (ясны хэмийн шинжилгээ)	23	Тархи нугасны шингэний ерөнхий шинжилгээ
10	АСТН	24	Цусны хийн шинжилгээ
11	ANA-9 Line	25	Шүүдэст шингэний ерөнхий шинжилгээ
12	Адренкортикотропны даавар-АТКГ	26	Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой хо)
13	Витамин Д нийт	27	Улаан хоолойн зүрхний хэт авиан шинжилгээ
14	Глюкозжсон гемоглобин	28	Хэт авиан хяналтанд хийх нарийн зүүний хатгалт (Бамбай, хөх, зөөлөн эд)
		29	Булчингийн цахилгаан бичлэг (EMG)

10. Эрчимт эмчилгээний тасагт эмчилгээ хийсэн ор хоногоос хамаарч эрчимт эмчилгээний төлбөрийг олгоно.
Үүнд:
10.1. Эрчимт эмчилгээний стандарт ор хоног буюу эрчимт эмчилгээний тасагт 3-6 өдөр эмчилсэн бол А,В,С,D бүлэгт хамаарах төлбөрийг олгоно.
10.2. Эрчимт эмчилгээний тасагт 3-аас доош хоног эмчилсэн бол хоног тутамд 250000 төгрөг хасаж олгоно.
10.3. Эрчимт эмчилгээний тасагт 7-12 хоног эмчилсэн бол 7 дахь хоногоос хоног тутамд 250000 төгрөг нэмж олгоно.
10.4. Эрчимт эмчилгээний тасагт 12-оос дээш хоног эмчилсэн бол хоног тутамд 150000 төгрөг нэмж олгоно.

		<p>10.5. Эрчимт эмчилгээний тасагт хоног болоогүй тохиолдлыг /эмнэлэг дотор, эмнэлэг хооронд шилжсэн, нас барсан/ D бүлгийн 30 хувиар санхүүжүүлнэ</p> <p>11. Төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллага нь үндсэн оношийн хүрээнд, үндсэн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага нь үндсэн эсвэл шинж тэмдгийн оношоор кодолж нэхэмжлэл илгээнэ.</p>	
<p>4.2. Эмийн эмчилгээ</p>	<p>Өвчний учир, эмчийн заалтаар хэвтүүлэн эмчилсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>- Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай үйлдэл, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор давтан 30 хоногийн дотор нэг эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлэн эмчлүүлсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд давтан хэвтэлтийг санхүүжүүлэхгүй.</p> <p>- Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай байдал, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор 30 хоногийн дотор өөр эрүүл мэндийн байгууллагад давтан хэвтүүлэн эмчлүүлсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд эхний хэвтэлтийг санхүүжүүлэхгүй, дараа сард олгох санхүүжилтээс хасаж тооцно.</p>	<p>Хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацаанд хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо лабораторийн шинжилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна. Жич: “Миелом ба плазмоцитын өмөн”-ийн үеийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд дээр дурдсан нийтлэг зардлуудаас гадна хэвтүүлэн эмчлэх үеийн хими болон туяа эмчилгээний зардал багтсан болно.</p>
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор тооцож, шилжин хэвтсэн оношийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ. Энэхүү тасаг хооронд шилжсэн шилжилттэй холбоотойгоор энэхүү журмын 5.1-т заасан иргэний хариуцан төлсөн төлбөрийн хэмжээнд зөрүү үүссэн тохиолдолд илүү гарсан зөрүүг эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид буцаан олгох, эсхүл дутуу тохиолдолд зөрүүг даатгуулагч эрүүл мэндийн байгууллагад нөхөн төлнө. 2. Эмийн эмчилгээний А оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн хавсарсан эмгэгтэй, эмнэлзүйн хүнд зэргийн тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн, хавсарсан эмийн эмчилгээ хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ. 3. Эмийн эмчилгээний В оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүндэвтэр зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн, эмийн эмчилгээ хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ. 4. Жирэмсний 37 долоо хоногтой эмгэгийн үеийн эмчилгээ хийлгэж байгаад үргэлжлүүлэн төрөх тохиолдолд тухайн эмгэгийг эмчлэх болон төрөх оношийн хамааралтай бүлгээр тус бүр санхүүжүүлнэ. 	
<p>4.3. Мэс засал</p>	<p>Даатгуулагчийн өвчний учир, эмчийн заалтаар хийлгэсэн мэс заслын тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>1. Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай байдал, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор 30 хоногийн дотор нэг эрүүл мэндийн байгууллагад давтан мэс засал хийлгэсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд давтан мэс заслыг санхүүжүүлэхгүй.</p>	<p>Мэс заслын тусламж, үйлчилгээ (мэс засал, мэдээгүйжүүлэг, сэрээх үйл ажиллагаа)-ний нийт зардлын бүрэлдэхүүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх хугацааны мэс засал, мэдээгүйжүүлэг, сэрээх үеийн хөдөлмөрийн зардал, холбогдох хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн, мэс заслын хэрэгсэл, протез, (өндөр өртөг бүхий болон бусад), эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, сэргээн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал, бусад зардал хамаарна.</p>

		<p>2. Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай байдал, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор 30 хоногийн дотор өөр эрүүл мэндийн байгууллагад давтан мэс засал хийлгэсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд эхний хийгдсэн мэс заслыг санхүүжүүлэхгүй, дараа сард олгох санхүүжилтээс хасаж тооцно.</p>	
	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт</p> <p>баримтлах</p>		<ol style="list-style-type: none"> 1. Алсын дуудлагаар ажилласан эмчийн хийсэн мэс заслын тусламж, үйлчилгээг мэс засал хийгдсэн орон нутгийн эмнэлгийн тохиолдолд бүртгэн, санхүүжилтийг тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага руу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. Хэрэв алсын дуудлагаар очсон эмч нь тухайн мэс засалд хэрэглэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протезыг өөрийн ажиллаж буй эмнэлгээс авч, тухайн мэс засалд ашигласан тохиолдолд орон нутгийн эмнэлэг нь мэс заслын хэрэгслийн зардлыг тухайн лавлагаа шатлалын эмнэлгийн тендерийн бодит үнээр нь тооцон, тус лавлагаа шатлалын эмнэлэг рүү шилжүүлнэ 2. Нэг хэвтэлтээр хос эрхтэнд ижил мэс засал хийсэн тохиолдолд тухайн мэс заслын оношийн хамааралтай бүлгийн нийт төлбөрийн хэмжээг 1.8 дахин үржүүлсэн дүнгээр санхүүжүүлнэ. Хэрэв тухайн оношийн хамааралтай бүлэг нь иргэнээс төлөх хамтын төлбөртэй тохиолдолд хамтын төлбөрийн хэмжээг мөн 1.8 дахин үржүүлсэн хэмжээгээр тооцон иргэнээр төлүүлнэ. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ. Энэхүү тасаг хооронд шилжсэн шилжилттэй холбоотойгоор энэхүү журмын 5.1-т заасан иргэний хариуцан төлсөн төлбөрийн хэмжээнд зөрүү үүссэн тохиолдолд илүү гарсан зөрүүг эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид буцаан олгох, эсхүл дутуу тохиолдолд зөрүүг даатгуулагч эрүүл мэндийн байгууллагад нөхөн төлнө. 3. Заалт гаргасан мэс засал нь амжилтгүй болсноос тухайн мэс заслыг өөр аргаар хийсэн тохиолдолд сүүлийнх нь хийгдсэн мэс заслын төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ. 4. Даатгуулагчийн мэс заслын тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг мэс заслын тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор тооцож, шилжин хэвтсэн оношийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ. Энэхүү тасаг хооронд шилжсэн шилжилттэй холбоотойгоор энэхүү журмын 5.1-т заасан иргэний хариуцан төлсөн төлбөрийн хэмжээнд зөрүү үүссэн тохиолдолд илүү гарсан зөрүүг эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид буцаан олгох, эсхүл дутуу тохиолдолд зөрүүг даатгуулагч эрүүл мэндийн байгууллагад нөхөн төлнө. 5. Орон нутгийн ЭМБ нь зайлшгүй шаардлагаар даатгалын байгууллагатай гэрээгүй мэс заслын ОХБ-ээр нэхэмжлэл илгээж, санхүүжиж болох бөгөөд дараах зохицуулалтыг мөрдөнө. Үүнд: <ol style="list-style-type: none"> 5.1. Гэнэтийн осол аваар гэх мэт эмнэлгийн яаралтай тусламжаар хийгдсэн мэс засал, эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх хүсэлтийг мэс засал хийгдсэнээс 24 цагийн дотор лавлагаа шатлалын эмнэлгээс алсын дуудлага хүссэн мэдээлэл, алсын дуудлагаар ирсэн багийн хийсэн мэс заслын мэдээллийн хамт даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд ирүүлсэн мэдээллийг нягталсны үндсэн дээр тухайн тохиолдлыг нэхэмжлэлийг хүлээн авах эсэх шийдвэрийг гаргана. 5.2. Яаралтай бус, төлөвлөгөөт мэс засал хийх тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгтэй төлөвлөгөөт мэс засал хийх гэрээ эсхүл албан бичиг, мэс засал хийх эмчийн мэдээлэл бүхий мэдээлэл бүхий хүсэлтийг төлөвлөгөөт мэс засал хийхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд ирүүлсэн мэдээллийг нягталсны үндсэн дээр тухайн тохиолдлыг нэхэмжлэлийг хүлээн авах, эсэх шийдвэрийг гаргана. Төлөвлөгөөт мэс засал хийх, эмч илгээх зохицуулалт, гэрээг зөвхөн эмнэлэг хооронд хийх бөгөөд эмчтэй хийсэн гэрээний нэхэмжлэлийг хүлээн авахгүй.

		<p>6. Мэс заслын эмчилгээ А оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүнд зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ.</p> <p>7. Мэс заслын эмчилгээ В оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүндэвтэр зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ.</p> <p>8. Мэс заслын эмчилгээ С оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хөнгөн зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдолд санхүүжүүлнэ.</p>
<p>4.4. Эрхтэн шилжүүлэх мэс засал</p>	<p>Эмчийн заалтаар хийгдэж буй “Эрхтэн шилжүүлэх мэс засал”-ын тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Эрхтэн шилжүүлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эрхтэн шилжүүлэх мэс заслын болон эрчимт эмчилгээний зардал, хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн, бүх төрлийн мэс заслын хэрэгсэл, протез, (өндөр өртөг бүхий болон бусад), эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, шинжилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>1. Донорыг Z өвчний кодоор, реципиентийг холбогдох үндсэн оношоор кодолж, бүртгэх ба донорыг тусад нь нэхэмжлэхгүй.</p>
<p>4.5. Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх системийн хими эмчилгээ</p>	<p>Эмчийн заалтаар хийгдэж буй “Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх системийн хими эмчилгээ”-ний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх системийн хими эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацаанд хэрэглэсэн системийн хими эмчилгээний эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилахуйн болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>4.6. Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх химийн бай эмчилгээ</p>	<p>Эмчийн заалтаар хийгдэж буй “Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх химийн бай эмчилгээ” (эмээс бусад тусламж, үйлчилгээ)-ний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх химийн бай эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацаанд хэрэглэсэн химийн бай эмчилгээний эм тарианаас бусад эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилахуйн болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна. Химийн бай эмчилгээнд шаардах эм, тариаг энэ тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын дагуу 5 дугаар хавсралтад заасан эм тарианы дагуу багцаар нь гүйцэтгэлийг нь хянаж санхүүжүүлнэ.</p>
<p>4.7.Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх системийн хими эмчилгээ, бай эмчилгээ, системийн хими болон бай эмчилгээний хослолыг санхүүжүүлэхэд баримтлах ерөнхий зохицуулалт</p>		<p>1. Хэрэв даатгуулагч эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх үед хорт хавдрын системийн хими, бай эмчилгээг туяа эмчилгээтэй хавсран хийсэн тохиолдолд хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх холбогдох хими эмчилгээний зардал дээр хэвтүүлэн эмчлэх үед хийсэн туяа эмчилгээний тохиолдлын тоогоор энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан хорт хавдрын өдрийн туяаны эмчилгээний холбогдох ОХБ-ийн зардлын хэмжээгээр төлбөрийн хэмжээг нэмж санхүүжүүлнэ.</p> <p>2. Хорт хавдраас бусад өвчнийг хэвтүүлэн эмчлэх явцад зайлшгүй шаардлагаар химийн эмчилгээ хийгдсэн тохиолдолд химийн эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй. Учир нь уг зардал нь тухайн тусламж, үйлчилгээний эмийн эмчилгээний зардалд багтсан болно.</p> <p>3. Хорт хавдрын системийн химийн эмчилгээг химийн бай эмчилгээтэй хавсран хийх тохиолдолд симтеийн химийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэх ба эмийг энэхүү тогтоолын 5 дугаар хавсралтын журмыг үндэслэн, 6 дугаар хавсралтад заасан эмийг тусад нэмэлтээр санхүүжүүлнэ.</p> <p>4. Хэвтүүлэн эмчилсэн системийн химийн эмчилгээний нэхэмжлэлийг илгээхдээ Z онош болон үндсэн хавдрын оношийг заавал хамтад нь бүртгэн илгээнэ.</p>

		5. Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх системийн химийн эмчилгээг химийн бай эмчилгээтэй хавсран хийсэн тохиолдолд системийн химийн эмчилгээний ОХБ –ээр нэхэмжилж, санхүүжүүлнэ.
4.8. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	Даатгуулагчид эмчийн заалтаар хийсэн хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацаанд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	Даатгуулагчид хөнгөвчлөх эмчилгээг үзүүлэх үед эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг үзүүлсэн бол эрчимт эмчилгээний холбогдох оношийн хамааралтай бүлгээр давхар санхүүжүүлнэ.
4.9. Нийт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд баримтлах нийтлэг зохицуулалт		<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн байгууллага тухайн иргэний хэвтүүлэн эмчлэхэд илгээх бичиг шаардахгүй бөгөөд эмчийн заалтаар хэвтэх бичигт үндэслэн хэвтүүлэн эмчилнэ. 2. “Ангилалдаагүй бусад” оношийн хамааралтай бүлэгт ОХБ-ийн 1-552 дүгээр оношийн хамааралтай бүлэгт тусаагүй, жилд улсын хэмжээнд 20-иос доош удаа тохиолдсон өвчин эмгэгийн онош, үйлдлээр үзүүлэх хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хамаарна. 3. Даатгуулагч хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авч байх хугацаандаа амбулаторийн тусламж, үйлчилгээг авсан тохиолдолд тухайн амбулаторийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхгүй. 4. Эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авалгүйгээр хуанлийн 30 хоногийн дотор шууд хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд тухайн хэвтүүлэн эмчилсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг санхүүжүүлэхгүй. 5. Хэвтүүлэн эмчлэх тусламж авч байгаа даатгуулагчдад нэг өвчний түүх үүсгэх бөгөөд тасаг дамжин эмчлүүлэх, сар дамнан хэвтүүлэн эмчлүүлэх нь өөр өвчний түүх нээх, шинэ нэхэмжлэл үүсгэх үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн гарах үеийн оношийн хамаарах бүлгээр нэг удаа санхүүжүүлнэ. 6. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг илгээхдээ дараах шаардлагыг хангасан байх бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахгүй, санхүүжүүлэхгүй. Үүнд: <ol style="list-style-type: none"> 6.1. Хэвтүүлэн эмчлэх хугацаанд оношлогдсон хавсарсан өвчнийг нэг бүрчлэн бүртгэж нэхэмжлэлд илгээнэ. 6.2. Нэхэмжлэлийг илгээхдээ тухайн даатгуулагчийн гарах үеийн онош, оношийн хамааралтай бүлгийн дугаараар нэхэмжлэлийг илгээнэ. 6.3. Нэхэмжлэлд даатгуулагчийн өвчний онош, үйлдлийг ICD10 болон ICD9 ангиллын дэлгэрэнгүй хувилбараар илгээнэ. 6.4. Хэвтүүлэн эмчлэх бүх тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хийгдсэн оношилгоо, шинжилгээ, эмийн эмчилгээ, ажилбарыг үйлдлийн кодоор, эмнэлгийн хэрэгсэлийг нэг бүрчлэн цахим системд бүртгэж нэхэмжлэлийг илгээнэ. 7. Тусламж, үйлчилгээг үзүүлж дууссанаас хойш 24 цагийн дотор, нийтээр амрах баяр ёслолын өдөр таарсан бол дараагийн ажлын өдөрт багтаан даатгалын байгууллагад нэхэмжлэлийг илгээх бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахгүй. 8. Нэхэмжлэл үүсгэхдээ даатгуулагчийн регистрийн дугаар, оношийн хамааралтай бүлэг, онош, үйлдлийн код алдаатай илгээж мөнгөн дүн тооцоологдоогүй тохиолдолд битүүмж хааснаас хойш 24 цагийн дотор засварлах боломжтой. 9. Даатгуулагчийг сарын сүүлийн өдөр эмнэлгээс гаргасан тохиолдолд тухайн өдрөөрөө тасалбар болгож нэхэмжлэлийг үүсгэж илгээнэ. Хэрэв дараа сард нэхэмжлэл үүсгэж илгээсэн тохиолдолд нэхэмжлэлийг хүлээж авахгүй.

	<p>10. Даатгуулагчийг эмнэлгээс гаргахдаа өвчтөн шилжүүлэх журмын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагын хяналтад шилжүүлнэ.</p> <p>11. Шинээр төрсөн нярайд хийгдэх эрт илрүүлгийн үзлэгийн хийсэн тохиолдолд төрлөгийн үеийн ОХБ-ын төлбөр дээр холбогдох зардлыг (52,000 төгрөгөөр) нэмж санхүүжүүлэх бөгөөд хийгдсэн үзлэг, шинжилгээний үр дүнг цахим системд бүртгэж нэхэмжлэлийг ирүүлнэ.</p> <p>12. Төрийн тусгай чиг үүргийн албан хаагчдад үйлчлэх эрүүл мэндийн байгууллага нь “Ангилалдаагүй бусад” оношийн хамааралтай бүлгээр онош харгалзахгүй үйлчлэх бөгөөд Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн байгууллагатай энэхүү оношийн хамааралтай бүлгийн тоо хэмжээг гэрээнд тусгаж зохицуулна.</p>
5. Сэргээн засах тусламж, үйлчилгээ	
5.1. Сэргээн засахын амбулаторийн тусламж, үйлчилгээ	<p>Даатгуулагчийн өвчний учир эмчийн заалтаар лавлагаа шатлалын, сэргээн засах амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Сэргээн засах амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд сэргээн засах мэргэжлийн эмчийн үзлэг холбогдох бусад зардал хамаарна.</p>
5.2. Сэргээн засахын өдрийн эмчилгээ	<p>Даатгуулагч лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас цочмог өвчин, эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлсний дараа эмчийн заалтаар тухайн оношид хамаарах сэргээн засах тусламж, үйлчилгээнд илгээсэн тохиолдлыг өдрийн сэргээн засах тусламжийн нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Даатгуулагчид сэргээн засахын өдрийн тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ.</p> <p>Сэргээн засахын өдрийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, шинжилгээ, засал, дасгал, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
5.3. Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	<p>Даатгуулагч лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас цочмог өвчин, эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлсний дараа эмчийн заалтаар тухайн оношид хамаарах сэргээн засах тусламж, үйлчилгээнд илгээсэн тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх сэргээн засах тусламжийн нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>Боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний багцад хамаарахгүй.</p> <p>Сувиллын байгууллагаас үзүүлэх сэргээн засахын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхгүй.</p> <p>Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, засал, дасгал, эм, эмнэлгийн хэрэгсэл, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p> <p>Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p> <p>1. Цочмогдуу үеийн сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг цочмог үеийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага руу өвчтөн шилжүүлэх журмын дагуу шилжүүлэн эмчилсэн тохиолдлыг даатгалаас санхүүжүүлнэ.</p> <p>2. Сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлыг санхүүжүүлэхэд баримтлах дундаж ор хоногийг сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрлөөс нь хамааруулан даатгалын байгууллагаас ялгавартай тогтоож чанар, төлбөрийн хяналтаар шийдвэрлэнэ.</p> <p>3. Даатгуулагчид үзүүлсэн сэргээн засах өдрийн болон хэвтүүлэн эмчлэх тусламжийн үр дүнг нэхэмжлэлд тусгах ба даатгуулагчийн алдагдсан үйл ажиллагаа сайжирсан нь чанар, төлбөрийн хяналтаар нотлогдвол тухайн тусламжийг давтан үзүүлэх нөхцөл болно.</p>

		<p>4. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэж нэмэлт санхүүгийн урамшуулал олгож болох ба үүнийг тухайн ЭМБ болон даатгалын байгууллага хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.</p> <p>5. Даатгуулагчийг эмнэлгээс гаргахдаа өвчтөн шилжүүлэх журмын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагын хяналтад шилжүүлнэ.</p>	
6. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ			
6.1 Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээ	<p>Даатгуулагчийн өвчний учир болон эрүүл мэндэд нөлөөлж буй бусад нөхцөлийн улмаас эмчийн илгээлтээр лавлагаа шатлалын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо болон холбогдох бусад зардал хамаарна.</p>	
6.2. Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээ	<p>Уламжлалт анагаах ухааны өдрийн эмийн эмчилгээ нь нэг оношоор 5-аас доошгүй хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Даатгуулагчид уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацаанд хэрэглэгдэх эм, тан, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, зөвлөгөө, бариа засал, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
6.3. Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	<p>Даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор бүртгэж, шилжин хэвтсэн буюу тухайн даатгуулагчийн эмнэлгээс гарах үеийн оношийн хамааралтай бүлгийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ.</p>	<p>Сувиллын байгууллагаас үзүүлэх уламжлалтын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхгүй.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацааны туршид хэрэглэгдэх, эм, тан, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо, шинжилгээ, эмчийн үзлэг, зөвлөгөө, бариа засал, сэргээн засах болон сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал, хоолны зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.</p>
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Даатгалын байгууллагаас уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлыг санхүүжүүлэхэд баримтлах дундаж ор хоногийг тогтооно. 2. Тогтоолын “Уламжлалтын ангилагдаагүй бусад” оношийн хамааралтай бүлэгт ОХБ-ийн жагсаалтын 51370011-51370024 код бүхий оношийн хамааралтай бүлэгт тусгагдаагүй, жилд 20-иос доош удаа тохиолдсон өвчин эмгэгийн оношоор үзүүлэх уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хамаарна. 	
7. Яаралтай тусламж			

7.1.Яаралтай тусламж	<p>Даатгуулагчид үзүүлсэн яаралтай тусламжийн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцон, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p>	<p>Яаралтай тусламж, үйлчилгээг нэхэмжлэхдээ зарцуулсан бодит зардлаас өндөр тариф бүхий ангиллаар нэхэмжилсэн нь чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар тогтоогдсон болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.</p>	<p>Яаралтай тусламжийн А ангилал буюу амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, амилуулах суурь болон лавшруулсан тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, ажилбар, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p> <p>Яаралтай тусламжийн В ангилал хүнд хэлбэрийн цус багадалтын үеийн тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилахуйн тусламж, үйлчилгээ, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, эмчилгээ, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p> <p>Яаралтай тусламжийн С ангиллын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилахуйн тусламж, үйлчилгээ, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, ажилбар, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p> <p>Яаралтай тусламжийн D ангиллын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилахуйн тусламж, үйлчилгээ, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p> <p>Яаралтай тусламжийн E ангиллын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилахуйн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, ажилбар, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p> <p>Яаралтай тусламжийн F ангиллын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, сувилахуйн тусламж, үйлчилгээ, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт баримтлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Жирэмслэлт, төрөхөөс бусад шалтгааны улмаас яаралтай тусламж, үйлчилгээг нэг ЭМБ-д 12 цагийн дотор давтан үзүүлсэн бол 2 дахь тохиолдлоос эхлэн нэхэмжилсэн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээний 50%-иар тооцож санхүүжүүлнэ. 2. Яаралтай тусламжийг нэг иргэнд 2 өөр ЭМБ-д 12 цагийн дотор үзүүлсэн тохиолдлыг 100% хяналтын түүвэрт авч чанар, төлбөрийн хяналтын үр дүнгээр санхүүжилтийг шийдвэрлэнэ. 3. Яаралтай тусламж үзүүлсэнээс хойш 24 цагийн дотор тухайн байгууллагадаа хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд яаралтай тусламжийн зардлыг санхүүжүүлэхгүй. 4. Ажлын цагаар буюу 08.30 – 17.30 цагийн хооронд үзүүлсэн яаралтай тусламжийн “А, В, С” ангиллаас бусад ангиллын үед үзүүлсэн яаралтай тусламжийн тохиолдлыг (осол, гэмтэл, жирэмсэн, төрөх, нярайгаас бусад) тухайн ангилалд хамаарах төлбөрийн хэмжээний 80 хувьтай тэнцэх дүнгээр санхүүжүүлнэ. 5. Яаралтай тусламж, үйлчилгээг эрэмбэлэн ангилж, бүртгэхдээ ЭМС-ын тушаалаар зохицуулсан эрэмбэлэн ангилалтыг мөрдөнө. 	

6. Яаралтай тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг яаралтай тусламжийн тасагт үзүүлсэн тусламж, үйлчилгээнд зарцуулсан зардалд үндэслэн А, В, С, D, E, F ангиллаар санхүүжүүлэх бөгөөд ангилал тус бүрт дараах хүснэгтээр тодорхойлсон тусламж, үйлчилгээг зайлшгүй хийсэн байна.

Хийгдэх тусламж, үйлчилгээний төрөл	А ангилал	В ангилал	С Ангилал	D ангилал	E ангилал	F ангилал
Эмчийн үзлэг, зөвлөгөө	✓	✓	✓	✓	✓	✓
Сувилагчийн үзлэг, хяналт	✓	✓	✓	✓	✓	✓
Лабораторийн шинжилгээ	✓	✓	✓	✓		
Багажийн оношилгоо	✓	✓	✓	✓		
Ажилбар	✓		✓		✓	
Эмийн эмчилгээ	✓	✓	✓	✓	✓	
Цус, цусан бүтээгдэхүүн хийх		✓				
Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ	✓					

7. Яаралтай тусламжийн нэгж тохиолдлын санхүүжүүлэх эсэхийг тухайн нэхэмжилсэн ангилалд хамаарах зардлыг гаргасан эсэхийг чанар, төлбөрийн хяналтаар шийдвэрлэнэ.

8. Яаралтай тусламжийн тухайн ангилал дах хийгдэх шаардлагатай тусламжууд бүрэн хийгдсэн тохиолдолд тус багцаар санхүүжүүлнэ. Тухайн ангилалын багц дутуу тохиолдол санхүүжүүлэхгүй.

9. Яаралтай тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн нь тухайн эмнэлзүйн тохиолдол, нас, хүйсээс хамаарч харилцан адилгүй байх бөгөөд дээрх хүснэгт-д заасны дагуу яаралтай тусламжийн ангилалд хамаарах дараах тусламж, үйлчилгээ зайлшгүй үзүүлсэн байна. Үүнд:

Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн бүрэлдэхүүн хэсгүүд:

- Шээсний ерөнхий шинжилгээ, цусны ерөнхий шинжилгээ, угаарын хий хордолтын карбоксиметрээр үзэх бусад шаардлагатай оношилгоо, шинжилгээ /зөвхөн нярайд билиметрээр билирубин тодорхойлох/ шинжилгээ авах үйлдэл
- Хэвлийн эхо эсхүл рентген оношилгоо, зүрхний цахилгаан бичлэг бусад шаардлагатай оношилгоо, шинжилгээ
- Эм, тариа, тарилга хийх үйлдэл
- Дараах ажилбарын аль нэгийг /Чих, хамар, хүй цэвэрлэх, амьсгалын замын соруулга, угаартсан үеийн усан эмчилгээ, биеэс гадны биет авах, ходоод угаах, ходоодонд зонд тавих, хамрын чихээс, уян зүү тавих гэх мэт/

Насанд хүрэгчдэд үзүүлэх яаралтай тусламжийн бүрэлдэхүүн хэсгүүд:

- Цусны ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, бусад шаардлагатай шинжилгээ, шинжилгээ авах үйлдэл
- Зүрхний цахилгаан бичлэг, эхо, рентген
- Эм, тариа, уян зүү тавих, тарилга хийх үйлдэл
- Дараах ажилбарын аль нэгийг /Ходоодонд зонд тавих, ходоод угаах, бургуй тавих, хамрын чихээс, биеэс гадны биет авах гэх мэт/

Жирэмсэн, эмэгтэйчүүдэд үзүүлэх яаралтай тусламжийн бүрэлдэхүүн хэсгүүд:

		<ul style="list-style-type: none"> - Цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, эсхүл хүний хорионгонадотропин үзэх, бусад шаардлагатай шинжилгээ, шинжилгээ авах үйлдэл - Хэвлийн эхо, үтрээний эхо, эсхүл ургийн зүрхний цахилгаан бичлэг бусад шаардлагатай оношилгоо - Эм, тариа, уян зүү тавих, тарилга хийх үйлдэл - Дараах ажилбарын аль нэгийг /Оёдол, боолт, шарх цэгцлэх, эмэгтэйчүүдийн цэвэрлэгээ гэх мэт/ <p>Хордлого, осол, гэмтлийн яаралтай тусламжийн бүрэлдэхүүн хэсгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Цусны бүлэг, угаарын хий хордолтын карбоксиметрээр үзэх, бусад шаардлагатай шинжилгээ, шинжилгээ авах үйлдэл - Рентген эсхүл хэвлийн эхо бусад шаардлагатай оношилгоо - Эм, тариа, уян зүү тавих тарилга хийх үйлдэл - Дараах ажилбарын аль нэгийг хийсэн байх /Оёдол, боолт, шарх цэгцлэх, гөлтгөнө тавих, ходоод угаах, ходоодны зонд, биеэс гадны биет авах, хамрын чихээс, мултарсан үе оруулах, хугарал засах, зөөлөн болон ясны татлага хийх, хөлдөлтийн үеийн дулааны эмчилгээ гэх мэт/ <p>Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Шаардлагатай оношилгоо, шинжилгээ, шинжилгээ авах үйлдэл - Эмийн эмчилгээ, уян зүү тавих тарилга хийх үйлдэл - Амилуулах суурь болон лавшруулсан тусламж, үйлчилгээнээс аль нэгийг хийсэн байх /Интубаци тавих, зүрхний шууд бус массаж хийх, зохиомол амьсгалд авах, артерид гуурс тавих, төвийн венийн гуурс тавих, тархи нугасны шингэн авах гэх мэт/ <p>10. Цус сэлбэлтийг насанд хүрэгчдийн хүнд хэлбэрийн цус багадагт оношилгоо, шинжилгээгээр нотлогдсон, эмнэлэгт зайлшгүй хэвтүүлэн эмчлэх шаардлагагүй тохиолдолд хийнэ.</p> <p>11. Яаралтай тусламжийн С ангилалд СТ, MRI шинжилгээг нийт тохиолдлын 7 хувьд хийсэн байхыг шаардана. Хэрэв нийт сарын нэхэмжлэлд 7 хувьд хүрч хийгээгүй бол хийгээгүй тохиолдлын тоогоор Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын хавсралтаар баталсан төлбөрийн хэмжээгээр бууруулж санхүүжүүлнэ.</p> <p>12. Яаралтай тусламжийн Е ангилалын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх явцад эмийн эсхүл лабораторийн тусламж үйлчилгээний зардал тус оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээний 70 хувиас хэтэрсэн тохиолдолд яаралтай тусламжийн F ангилалаар нэхэмжилж болно.</p>
8.Түргэн тусламж		
<p>8.1. Түргэн тусламж</p>	<p>Түргэн тусламжийн нэг дуудлагыг нэхэмжлэлийн нэг тохиолдолд тооцно.</p>	<p>Түргэн тусламжийн дуудлагад эмнэлэг хоорондын эмчийн дуудлагын үйлчилгээг тооцохгүй.</p> <p>Түргэн тусламжийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, газар дээр нь үзүүлсэн тусламж, үйлчилгээнд ашиглагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, тээвэр, 2 талын зайн шатахууны зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.</p>

	<p align="center">Санхүүжүүлэхэд зохицуулалт</p> <p align="center">баримтлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан түргэн тусламжийн оношийн хамааралтай бүлгийн “км” нь тухайн түргэн тусламжийн нэг талын зайг илэрхийлнэ. 2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймаг, дүүргийн эмнэлэг рүү, аймгаас Улаанбаатар хот руу эсхүл ойролцоо төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжтай эрүүл мэндийн байгууллага руу өвчнийг эмчийн хяналтын дор тээвэрлэн шилжүүлэхтэй холбоотой зардлыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан холбогдох түргэн тусламжийн бүлгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг баримтлан санхүүжүүлнэ. 3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн эмнэлгээс ирүүлсэн дуудлагын дагуу аймгаас өрх, сум тосгоны эмнэлэг рүү, Улаанбаатар хотоос аймаг руу эмч, баг очин, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн тохиолдлын зардлыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан холбогдох түргэн тусламжийн бүлгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг баримтлан санхүүжүүлнэ. 4. Түргэн тусламжийн хуурамч дуудлага өгч, үйлчилгээ авсан тохиолдолд тухайн түргэн тусламжийн харгалзах төлбөрийн хэмжээг баримтлан, төлбөрийг иргэнээр төлүүлнэ. 5. Алсын түргэн тусламж авч байгаа эрүүл мэндийн байгууллагад тухайн иргэний хэвтүүлэн эмчлэх тусламж үзүүлж байгаа тусламж үйлчилгээ бүртгэгдсэн байна. 6. Түргэн тусламж үзүүлэх явцад Монгол Улсын иргэний мэдээлэл тодорхойгүй үед дараах байдлаар кодлох ба эхний хоёр орон буюу үсгийг “ЯЯ” тэмдэглэгээгээр тэмдэглэх, 3-аас 10 дугаар орон буюу 8 цифрийг тухайн өдрийн огноогоор бүртгэж нэхэмжилнэ. Харин тус нэхэмжлэл нь нийт түргэн тусламжийн нэхэмжлэлийн тохиолдлын 10 хувиас ихгүй байх бөгөөд чанар, төлбөрийн хяналтад үндэслэн санхүүжүүлнэ. 	
9. Телемедициний тусламж, үйлчилгээ			
<p>9.1.Телемедициний тусламж, үйлчилгээ</p>	<p>1.Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиникийн хүсэлтийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас авч буй телемедициний тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэнэ.</p> <p>2.СТЭМТ-ийн хүсэлтийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн эмчээс авч буй телемедициний тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэнэ.</p>	<p>Эмнэлгийн мэргэжилтнээс үйлчлүүлэгчид хандсан зайн тусламж, үйлчилгээг телемедициний тусламжийн тохиолдолд тооцохгүй.</p>	<p>Телемедициний тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд зөвлөгөө өгч буй эмчийн зөвлөгөө, интернэтийн зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.</p>

	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт</p> <p>баримтлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эрчимт эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээ үед эмнэлзүйн тусгай програм хангамжийг ашиглан эмчилгээ, оношилгоо үзүүлсэн тохиолдолд телемедициний тусламж, үйлчилгээ гэж тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 2. Сүрьеэ өвчний телемедициний тусламж үйлчилгээнд аймгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвөөс сум, тосгоны эрүүл мэндийн төвд тусгай төхөөрөмж ашиглан мэргэжил арга зүйн тусламж үзүүлсэн тохиолдолд телемедициний тусламж, үйлчилгээ гэж тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 3. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах хяналтыг төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн төв аймгийн нэгдсэн эмнэлэгт тусгай төхөөрөмж ашиглан мэргэжил арга зүйн тусламж үзүүлсэн тохиолдолд телемедициний тусламж, үйлчилгээ гэж тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 4. Телемедициний тусламж үйлчилгээ авч байгаа эрүүл мэндийн байгууллагад эрчимт эмчилгээ болон хэвтүүлэн эмчлэх мэс заслын тусламж, үйлчилгээ, эрхтэн шилжүүлэн суулгах хяналтын үзлэг, сүрьеэ өвчний хяналтын үзлэг бүртгэгдсэн байх шаардлагатай. 	
10. Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ			
<p>10.1. Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ</p>	<p>Даатгуулагчийг эмчийн заалтаар сувилалд хэвтүүлэн эмчилсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож санхүүжүүлнэ.</p>	<p>Иргэн даатгуулагчийн авсан сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг хуанлийн жилд 1 удаа санхүүжүүлнэ.</p>	<p>Сувиллын байгууллагаас үзүүлэх сэргээн засах болон уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ болон холбогдох бусад зардал хамаарна</p>
	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт</p> <p>баримтлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сувиллын байгууллагаас үзүүлэх сувилалын тусламж, үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчид сувиллын үйлчилгээний төлбөрөөс тогтоолд заасан төлбөрийн хэмжээгээр хөнгөлөлт үзүүлнэ. 2. Сувиллын байгууллагаас үзүүлэх сэргээн засах болон уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд багтсан оношилгоо, шинжилгээг анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад хийлгэсэн тохиолдолд тухайн сувиллын дараа сард олгох дүнгээс хасаж санхүүжүүлнэ. 3. Сувиллын байгууллагаас үзүүлэх сэргээн засах болон уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд оношилгоо, шинжилгээний зардал багтсан байх тул даатгуулагчаас оношилгоо, шинжилгээг хийхтэй холбоотой нэмэлт төлбөр авахыг хориглоно. 4. Тодорхой өвчний дараагаар биеийг амрааж, нөхөн сэргээх тусламжийг үзүүлж байгаа тохиолдлыг сувиллын багцаар, уламжлалт болон сувиллыг хавсран хийж буй тохиолдолд сувиллын уламжлалтын багцаар, сэргээн засах болон сувиллыг хавсран хийж буй тохиолдолд сувиллын сэргээн засахын тусламжаар нэхэмжлэнэ. 5. Хэрэв Ахмад настны тухай хуулийн 10.1.2.-т “эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;” заасны дагуу сувиллаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг давхардуулан санхүүжүүлэхгүй. 	

11. ЭМД-ын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээний хувьд гуравдугаар хавсралтаар баталсан тодорхойлсон удирдамжаар зохицуулаагүй тохиолдлыг санхүүжүүлэх эсэхийг ЭМД-ын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

12. ЭМД-ын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхдээ энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад харгалзах “ЭМД-ын сангаас төлөх” төлбөрийн хэмжээг баримтална.

13. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан тусламж, үйлчилгээний чиглэл, зохицуулалтын хүрээнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үзүүлж буй тухайн тусламж, үйлчилгээг орон нутагт нутагшуулах зорилгоор эмч, мэргэжилтний багийг сэлгэн ажиллуулсан тохиолдолд багийн зүгээс нэг удаа очиж үйлчилгээ үзүүлэхдээ тухайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээг 1-20 тохиолдол хийвэл 50 хувь, 21-40 тохиолдол хийвэл 40 хувь, 41-ээс дээш тохиолдол хийвэл 30 хувиар нэмэгдүүлж санхүүжүүлэх, энэ нэмэгдэл нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажилласан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн багийн холбогдох зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана.

14. Эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас хамаарч амбулаторийн тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлэх чадамжгүйг хээс шалтгаалан иргэдэд чирэгдэл учирч буй тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай оношилгоо, шинжилгээг лавлагаа шатлал хооронд болон анхан шатнаас лавлагаа шатлалд эмчийн заалтаар шууд илгээж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн оношилгоо, шинжилгээг хийсэн эрүүл мэндийн байгууллагад Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ын жишиг төлбөрийн хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

15. Энэ журмын 6.5 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ иргэнийг чирэгдэлгүй, чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор сорьц тээвэрлэж болох бөгөөд энэ тохиолдолд иргэний танин баталгаажуулалт шаардахгүй.

ТӨЛБӨРИЙГ НЬ ТӨР ХАРИУЦАХ ЭМИЙН ЗАРДЛЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагаас төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор болон бусад хэлбэрээр эмчлэх өвчинд хэрэглэх эм (цаашид “төлбөрийг нь төр хариуцах эм” гэх)- ийг иргэн даатгуулагчдад олгох, олгосонтой холбогдох зардлыг тооцох, зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох үйл ажиллагаа эрхлэх гэрээ бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, тусгай эмнэлэг, өрх*, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулсны үндсэн дээр уг үйлчилгээг худалдан авч, санхүүжүүлнэ.

1.3. Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)-аас төлбөрийг нь төр хариуцах эмийг худалдан авах, санхүүжүүлэхдээ тухайн жилийн ЭМДС-ийн төлбөрийг нь төр хариуцах эмд зориулан батлагдсан зардлын төсөвт багтаана.

Хоёр. Төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэнийг тодорхойлох

2.1. Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалтад багтсан өвчнөөр өвдсөн иргэнийг эмчийн байнгын хяналтад авч, төлбөрийг нь төр хариуцах эм олгох эсэх шийдвэрийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвд Эмнэлэг, хяналтын комисс, төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт Эмч нарын зөвлөгөөний хурлаар /цаашид “зөвлөл” гэх/ шийднэ.

2.2. Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн Эмнэлэг, хяналтын комиссын хуралд тухайн иргэний харьяалах өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч заавал оролцоно.

2.3. Эмнэлэг, хяналтын комисс болон Эмч нарын зөвлөгөөний хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргана. Үүнд:

2.3.1. Шинээр хяналтад орж буй өвчтөний оношийг баталгаажуулах, хяналтад авах эсэхийг шийдэх, хяналтад авсан тохиолдолд эмийн нэр төрөл, тун хэмжээг тогтоох, хяналтад орж буй хугацааг тодорхойлох, хяналтын үзлэгт ирж үзүүлэх хугацааг тогтоох;

2.3.2. Хяналтад байгаа өвчтөнүүдийн хувьд тухайн эмнэлгийн хяналтаас аймаг, дүүргийн эсхүл анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналт руу шилжүүлэх эсэх, шилжүүлсэн тохиолдолд тухайн иргэний уух эмийн нэр төрөл, тун хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, анхан шатлалын болон лавлагаа шатлалын эмнэлгийн үзлэгт ямар хугацаанд эргэн хянагдах зэргийг тодорхойлно.

2.4. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлэг, хяналтын комисс/ Эмч нарын зөвлөгөөний хурлын шийдвэр, тухайн өвчний иргэний үнэмлэх болон холбогдох мэдээлэл, баримтыг Эрүүл мэндийн даатгалын байгууллагын “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн системд бүртгүүлнэ.

2.5. “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн системд бүртгэгдсэн иргэнд тухайн жилд “төлбөрийг төр хариуцах эм” авах эрх үүсэх, эсвэл хүлээлтэд орох эсэх нь тухайн жилд ЭМДС-ын төлбөрийг нь төр хариуцах эмийн зардалд батлагдсан зардлаас хамаарна.

2.7. Хорт хавдрын дараах химийн бай эмчилгээнд шаардагдах эм, тариаг тухайн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлж буй эмнэлгүүдэд багцаар нь олгож хяналт тавьж санхүүжүүлэх бөгөөд энэ журмын 2.6 дах хэсгийг дагаж мөрдөхгүй байж болно.

Гурав. Төлбөрийг нь төр хариуцах эмийн жор бичих

3.1. Эрүүл мэндийн байгууллага нь “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт”-д багтсан өвчнөөр өвдсөн иргэний өвчнийг хянаж, төр төлбөрийг нь хариуцах эмийн жор бичих, үүнээс “сэтгэцэд нөлөөт” болон “мансууруулах” эмийн жор бичих эмч болон эм олгох эм зүйчийн мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газарт жил бүрийн 1 сарын 15-ны дотор хүргүүлж, хяналтын эмч тус бүрт “жор бичих эрх”, эм зүйч тус бүрт “эм олгох” эрх авна.

3.2. Төлбөрийг нь төр хариуцах эмийн жор бичих эрхтэй эмч нь өөрийн хяналтад буй, төлбөрийг нь төр хариуцах эм олгохоор зөвшөөрөгдсөн өвчтөнд үзлэг хийж, өвчний явцыг хянан, үзлэгийн тэмдэглэл бичсэнээр тухайн иргэнд “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн цахим жор бичих эрх үүсэх бөгөөд цахим жор бичихдээ “Эмийн жорын маягт, бичилт MNS 5376:2016” стандартыг мөрдлөг болгоно.

3.3. Цахим жорд эмчилгээний нэг удаагийн тун, хоногийн нийт тун, эмчилгээний хугацаа болон эмчилгээний нийт тунг тухайн өвчний эмнэлзүйн удирдамжид заасан хугацаагаар бичнэ.

3.4. “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн системд нэвтэрч цахим жор бичихийн тулд 1) цахим жор бичих хяналтын эмч болон 2) “Төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэн” аль аль нь тус тусын хурууны хээг заавал уншуулна.

3.5. Хурууны хээ уншуулах боломжгүй иргэдийн хувьд дор дурдсанаар зохицуулна.
Үүнд:

3.5.1. А) 18 нас хүрээгүй буюу хурууны хээний мэдээлэл нь иргэний бүртгэлийн нэгдсэн санд ороогүй хүүхэд; Б) Хэвтрийн болон хүнд өвчтэй иргэн; В) Сэтгэцийн зарим эмгэгтэй иргэний тус тус төлөөлж асран хамгаалагч нь хурууны хээгээ уншуулна.

3.5.2. Ажил мэргэжлийн онцлог болон бусад шалтгааны улмаас хурууны хээгүй, уншуулах боломжгүй иргэдийн хувьд “Хурууны хээ уншуулах боломжгүй

иргэдийн нэгдсэн бүртгэлийн сан”-д бүртгэгдсэн тохиолдолд болон ХДХВ-ийн халдвартай иргэдийн хурууны хээг таниулахгүй.

Дөрөв. Төлбөрийг нь төр хариуцах эмийг иргэнд олгох

4.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн багцаар гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага нь иргэн, даатгуулагчид “Төлбөрийг нь төр хариуцах эм” олгоно.

4.2. Жор баригч нь “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн цахим системд нэвтрэхдээ хурууны хээг заавал таниулна.

4.3. Жор баригч нь иргэнд хяналтын эмчийн бичсэн жор, эмийн үйлчлэл, эмийн хэрэглэх арга, үргэлжлэх хугацаа, гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар мэдээлэл өгнө.

4.4. Хорт хавдрын дараах бай эмчилгээний зарим эмийг амбулаториор уух боломжтой тохиолдолд эмчийн хяналтын дагуу олгоно.

Тав. Эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийг нь төр хариуцах эмийн нэхэмжлэл, нэхэмжлэлийн хяналт, санхүүжилт

5.1. Эмийн санч нь эм олгосны дараа “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн систем дэх олгох товчийг дарснаар цахим нэхэмжлэл бодит цагийн горимоор илгээгдэнэ.

5.2. Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн төлбөрийг нь төр хариуцах эмийн нэхэмжлэлд цахимаар болон түүврийн аргаар чанар, төлбөрийн хяналт хийж, хяналтын үр дүнд үндэслэн санхүүжилнэ.

5.3. Төлбөрийг нь төр хариуцах эмийн нэхэмжлэлд дараах цахим хяналтыг хийж, санхүүжүүлэх эсэхийг шийднэ. Үүнд:

5.3.1. Төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэн мөн эсэх /регистрийн дугаар дээр үндэслэх/

5.3.2. Төлбөрийг нь төр хариуцах эмийн олголтоос календарын 10 хоногийн дотор холбогдох өвчнөөр амбулаторийн хяналтын үзлэгт хамрагдсан эсэх

5.3.3. Төлбөрийг нь төр хариуцах эмийн жорыг оновчтой бичсэн эсэх /Тухайн өвчтөний нас, биеийн жин, өвчний онцлог зэргээс хамааран зохих эмийг зохих тун хэмжээгээр бичсэн эсэх, эмийн нэг удаагийн болон эмчилгээний тун хэмжээ эмнэлзүйн удирдамжийн дагуу эсэх, эмийн нийцэл зохицол гэх мэт/

5.4. “Төлбөрийг нь төр хариуцах эм” олгох иргэний мэдээлэлд үндэслэн, Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн байгууллага хооронд хийх “Тусламж, үйлчилгээ худалдах, худалдан авах” гэрээнд тухайн жилд тухайн ЭМБ-ын “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн үйл ажиллагаанд олгох нийт санхүүжилтийн дээд хэмжээг тусгана.

5.5. Эрүүл мэндийн байгууллагад “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийн санхүүжилтийг гэрээнд тусгасан нийт төсөвт багтаан, сар бүр гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

5.6. “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийг санхүүжүүлэхдээ тухайн эмийн нэг эх үүсвэрийн худалдан авалтын аргаар худалдан авсан эмийн үнийн дүн дээр тухайн эмийн үнийн дүнгээс хамаарч 5 хүртэлх хувийн урамшууллын санхүүжилтийг нэмэгдүүлж олгох бөгөөд хэрэв тухайн эм нь нэг эх үүсвэрийн худалдан авалтын аргаар аваагүй тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын холбогдох хуулийн дагуу худалдан авалтын үнийг ашиглана.

5.7. Эрүүл мэндийн байгууллага нь улсын хэмжээний нэгдсэн худалдан авалтын системээс эмийг худалдан аваагүйгээс болон бусад шалтгааны улмаас нэгдсэн худалдан авалтын үнэ эсхүл эрүүл мэндийн даатгалын байгууллагаас тогтоосон үнээс өндөр үнээр эм худалдан авсан нь нэмэлт санхүүжилт олгох, иргэн даатгуулагчийн шаардлагатай эмийг шаардлагатай тоо хэмжээнээс багаар олгох үндэслэл болохгүй. Үүнтэй холбогдох аливаа хариуцлагыг эрүүл мэндийн байгууллага үүрнэ.

5.8. Хорт хавдрын дараах бай эмчилгээний эм, тарианы зардлыг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан чадамж бүхий эрүүл мэндийн байгууллагатай тухайн тусламж, үйлчилгээний өмнөх жилийн гүйцэтгэл, чанар, үр дүнг харгалзан нийт төсвийн аргаар багцын гэрээ байгуулах бөгөөд гэрээнд заасны дагуу багц санхүүжилтийг хуваарийн дагуу олгож, гүйцэтгэлийг тухай бүр хянаж санхүүжүүлнэ.

5.9. Хорт хавдрын дараах бай эмчилгээний эм, тарианы зардлын төсвийн хэмжээг тооцохдоо Засгийн газраас баталсан нэгдсэн худалдан авалтын зохицуулалтын хүрээнд нийлүүлж буй үнээр тооцож багцаар нь төсөвлөж гэрээнд тусгана. Харин тухайн тусламж, үйлчилгээний зардлыг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан оношийн хамааралтай бүлэг болон холбогдох журмын дагуу санхүүжүүлнэ.

Зургаа. Оролцогч талуудын эрх, үүрэг

6.1. Даатгуулагчийн эрх, үүрэг

6.1.1. Тухайн эмнэлгийн амбулаторийн хяналтын үзлэг хийсэн эмчийн бичсэн жороор эмнэлгийн дотуур эмийн сангаас эрүүл мэндийн даатгалын сангийн дэмжлэгтэйгээр эмээ авах;

6.1.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрх бүхий эмч болон эмнэлгийн жор баригчаас төлбөрийг нь төр хариуцах эмийн талаар болон эмийн хэрэглэх арга, үргэлжлэх хугацаа, гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар мэдээлэл авах;

6.1.3. Эмчийн зааврын товллын дагуу хяналтын үзлэгт тогтмол хамрагдах;

6.1.4. Эмийг зааврын дагуу товлосон хугацаанд бүрэн уух;

6.1.5. Хууль, журам, заавар зөрчсөн, чанарын шаардлага хангаагүй эмээр үйлчилсэн зэрэг зөрчил гаргасан эрүүл мэндийн байгууллагуудыг холбогдох хяналт шалгалтын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэх, мэдээлэл өгөх, эрх ашгаа хамгаалуулах;

6.1.6. Үндсэн харьяаллаас өөр аймаг, нийслэл, суманд оршин сууж байгаа, эсвэл харьяаллаа өөрчилсөн тохиолдолд хяналтын эмчдээ мэдэгдэж, бүртгэлийн системд мэдээллээ шинэчлүүлэх.

6.2. Эмчийн эрх, үүрэг:

6.2.1. Төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэнийг тогтмол хугацаанд хянах бөгөөд эмчийн идэвхтэй хяналтад байх хугацаанд хэрэглэж байгаа эмийн эмчилгээний үр дүнг хяналтын графикийн дагуу тогтмол хянана.

6.2.2. “Эмийн жорын маягт, жор бичилт” Монгол улсын MNS 5376:2016 стандарт, эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасны дагуу олон улсын эмнэлзүйн удирдамж болон ЭМС-ын 2020 оны А/495дугаар тушаалаар батлагдсан “Цахимаар эмийн жор бичих, олгох заавар”-ыг мөрдөж эмийн жорыг ерөнхий нэршлээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан жагсаалтын хүрээнд латинаар бичих ба эдгээр эмээр эмчлэх явцад тун болон үргэлжлэх хугацааг өвчтөн бүрт эмчлэгч эмч тохируулж, хяналтын картанд тэмдэглэл хөтөлнө.

6.2.3. Төлбөрийг нь төр хариуцах эм бичих эрхтэй эмч нь эмчилгээний нийт тун, хоногийн тунг тухайн өвчний эмнэлзүйн удирдамжид заасан хугацаагаар бичих

6.2.4. Хяналтандаа ирэхгүй байгаа төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэн лүү залгаж, хяналтандаа тогтмол үзүүлэхийг шаардах, эмчилгээний үр дүнг сайн байлгахад анхаарах

6.2.5. Төлбөрийг нь төр хариуцах эмийн системд шинээр бүртгэгдэж буй иргэнд эм олгогдох хугацаа нь төсөвтэй холбоотой талаар болон бусад мэдээллийг өгөх

6.2.6. Шаардлагатай тохиолдолд эмийн нэр, төрөл, тун хэмжээг өөрчлөх саналыг зөвлөлөөр хэлэлцүүлэх

6.2.7. Төлбөрийг нь төр хариуцах эм олгох иргэнийг хяналтаас хасах, анхан эсвэл холбогдох лавлагаа шатлалд шилжүүлэх саналыг зөвлөлөөр хэлэлцүүлэх

6.2.8. Зөвлөлийн шийдвэрийн үр дүнг төлбөрийг нь төр хариуцах эмийн системд бүртгэх

6.3. Эм зүйчийн эрх, үүрэг:

6.3.1. Иргэнд эмчийн бичсэн төлбөрийг нь төр хариуцах эмийн жорд бичсэн эмийг хэрхэн уух, хадгалах болон эмийн талаарх мэдээллээр хангах.

6.3.2. Зөвхөн эмчийн бичсэн жорын дагуу эмийг олгох.

6.4. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг:

6.4.1. Эмнэлгийн дотуур эмийн сан нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим жорын системд холбогдох бөгөөд санхүүгийн болон эмийн бүртгэлийн цахим програм хангамжийг бүрэн ашиглах;

6.4.2. Төр төлбөрийг нь хариуцах эмийн худалдан авалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс худалдан авах ажлыг зохион байгуулж, төлбөрийг нь төр хариуцах эмийн жагсаалтад заасан эмээр үйлчилгээ үзүүлэх ба жагсаалт дахь нийт худалдааны нэрийн эмийн 90-ээс доошгүй хувийн нөөцийг эмнэлгийн эмийн санд бүрдүүлсэн байх;

6.4.3. Эмчийн бичсэн эмийн цахим жорд ерөнхий нэршлээр бичигдсэн эмийг худалдааны нэршлээр даатгуулагчид болон жор баригчид нэгэн зэрэг харагдах хоёр

талт дэлгэцийг байршуулж, дэлгэцэд эмийн нэр, тун хэмжээ, эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байгаа дүнг харуулдаг байх;

6.4.4. Эмнэлгийн эмийн сан нь даатгуулагчид цахим жороор үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг зааврын дагуу тогтоосон хугацаанд эрүүл мэндийн даатгалын байгууллагад цахимаар илгээх;

6.4.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан төлбөрийг нь төр хариуцах эмийн зардлыг хагас, бүтэн жилээр эрүүл мэндийн даатгалын байгууллагатай тооцоо нийлэх;

6.4.6. Эмнэлгийн эмийн сангийн стандартад заасан анхан шатны болон санхүүгийн баримтыг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж болгон хадгалах;

6.4.7. Төлбөрийг нь төр хариуцах эмийн талаар иргэд, даатгуулагчийг үнэн зөв мэдээллээр ханган ажиллах;

6.4.8. Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, эмийн цахим програм хангамжийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх;

6.4.9. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн байгууллага, даатгуулагч иргэдийн ёс зүй, харьцаа хандлагын талаар гомдол гаргах;

6.4.10. Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс худалдан авсан эмийн нэр төрөл, тоо хэмжээний мэдээллийг худалдан авалт хийсэн тохиолдол бүрд эрүүл мэндийн даатгалын газарт ирүүлэх;

6.4.11. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

6.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

6.5.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ) төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтэд шаардагдах төсвийг төлбөрийг нь төр хариуцах эмийн системд бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл, хэрэгцээнд үндэслэн, цахим дэлгүүрт орсон эмийн үнэ эсхүл нэгдсэн худалдан авалтын үнийг ашиглан эм тус бүрээр тооцно.

6.5.2. Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалын байгууллага хооронд мэдээллийн цахим тогтолцоог нэвтрүүлнэ.

6.5.3. Төлбөрийг нь төр хариуцах эмийн тайланд судалгаа хийж, үр дүнд үндэслэн холбогдох шийдвэрийг гаргана.

6.5.4. Эрүүл мэндийн даатгалын байцаагч, мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагын талаар болон ашиг сонирхлын зөрчлийн талаар эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн гомдлыг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэнэ.

6.5.5. Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллага болон эрх бүхий эмч нарын буруутай үйл ажиллагааны улмаас даатгуулагчдад болон эрүүл мэндийн даатгалын санд хохирол учруулсан нь тогтоогдвол Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хохирлыг албан тушаалтан болон хуулийн этгээдээр төлүүлнэ.

6.5.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Долоо. Хориглох зүйл

7.1. Даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хориглох зүйл:

7.1.1. Эмнэлгийн эмийн сангийн анхан шатны бүртгэл мэдээ, эмийн нэр төрөл, орлого, зарлагын баримт, тайланг буруу буюу дутуу хөтлөх, эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх;

7.1.2. Эм барих зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулах;

7.1.3. Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлгүй, хуурамч, чанарын баталгаагүй, хугацаа дууссан эмээр үйлчлэх;

7.1.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад санхүүгийн болон бусад асуудлаар худал мэдээлэл ирүүлэх, байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;

7.1.5. Төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, төөрөгдүүлэх, шалгалтад холбогдолтой баримт бичгийг засварлах, гэмтээх, устгах, шалгалтаас зайлсхийх, хуурамч баримт бичиг гаргаж өгнө.

7.1.6. Жор бичих эрхтэй эмч нь тухайн эрүүл мэндийн байгууллагаас гарсан үед жор бичих эрхийг түтгэлзүүлэх цахим хүсэлтийг илгээхгүй байх.

7.2. Даатгуулагчдад эмийн жор бичих эмчид хориглох зүйл

7.2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасан олон улсын эмнэлзүйн удирдамжийг баримтлахгүйгээр даатгуулагчийн өвчний онош, нас, хүйсэнд тохироогүй эм бичих;

7.2.2. Эмч амбулаторийн хяналтын үзлэг хийхгүйгээр даатгуулагчид эмийн жор бичих;

7.2.3. Эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрэх эрхийг өөр хүнд ашиглуулах;

7.2.4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг “Төлбөрийг нь төр хариуцах эм” олголтын системд бүртгэх;

7.2.5. Жорыг алдаатай бичих;

7.3. Даатгуулагчид хориглох зүйл

7.3.1. Өөр хүний бичиг баримтыг ашиглан эмийн жор бичүүлэх;

7.3.2. Эмчид үзүүлэхгүйгээр, мөн шаардлагагүй эмийн жор бичихийг эмчээс шаардах;

7.3.3. Хяналтын үзлэгийг таслах, эмчийн өгсөн заавар дүрмийг мөрдөхгүй байх, эмийг уухгүй тасалдуулах

7.3.4. Эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх, нэр хүндийг гутаан доромжлох, гүтгэх, худал мэдээллийг тараах, төөрөгдүүлэх, нийтэд дэлгэх.

7.4. Эмийн санчид хориглох зүйл

7.4.1. Эмчийн бичсэн жорд зааснаас өөр эм олгох, тун хэмжээг зөрүүлэх

7.4.2. Эм олгохтой холбоотой аливаа төлбөр иргэнээс нэхэх, төлүүлэх.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Төлбөрийг нь төр хариуцах эмээр үйлчлэх эмнэлэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс удаа дараа гомдол ирүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийг арилтал санхүүжилтийг түдгэлзүүлэх, дээрх зөрчил давтан илэрсэн, хуурамч баримт бичгээр санхүүжилт авсан нь нотлогдсон тохиолдолд гэрээг цуцлах, эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

8.3. Төлбөрийг нь төр хариуцах эмийн цахим жор бичих эрх бүхий эмч нар энэхүү журмыг зөрчсөн, даатгуулагч иргэдээс ирүүлсэн гомдол нь үндэслэлтэй нь нотлогдсон тохиолдолд тухайн эмчийн "эрүүл мэндийн даатгалын цахим систем"-д нэвтрэх эрхийг хааж, эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлын төлбөрийг бууруулах, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч олон нийтэд мэдээлнэ.

---oOo---

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоолын зургаадугаар хавсралт

ТӨРӨӨС ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ЗАРИМ ӨВЧИН ЭМГЭГ, ТҮҮНИЙ ЭМИЙН ЖАГСААЛТ, ХЭЛБЭР, ТУН

№	Эмийн олон улсын нэршил	Эм хэрэглэх өвчний ангилал	Эмийн хэлбэр	Эмийн тун	
1	Гемофиллийн эсрэг фактор	Гемофилли	хуурай фактор IX	250 ОУН - 3000 ОУН	
2	Гемофиллийн эсрэг фактор		хуурай фактор VIII	250 ОУН - 3000 ОУН	
3	Левотироксин	Гипотиреоз	шахмал	25мкг,50мкг,75мкг,100мкг,125мкг,150мкг	
4	Пилокарпин	Глаукома	нүдний дусал	0.5%,1%,2%	
5	Тимолол		нүдний дусал	0.25%,0.5%	
6	Ацикловир	Дархлалын олдмол хомсдол өвчин	шахмал	200мг,400мг,500мг,800мг	
7	Долутегравир+Абакавир+Ламивудин		бүрхүүлтэй шахмал	50мг+600мг+300мг	
8	Долутегравир		шахмал	50мг	
9	Соматропин	Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил	тарилгын уусмал	4 ОУН, 10 ОУН	
10	Галантамин	Паркинсоны өвчнөөс үүдэлтэй зөнөгрөл болон бусад шалтгааны зөнөгрөл, Алцгеймэрын өвчин	шахмал	8мг, 16мг	
11	Левадопа + Карбидопа		шахмал	250мг+25мг	
12	Изониазид	Сүрьеэ	шахмал	50мг,75мг,100мг,300мг	
13	Клофазимин		капсул	100мг	
14	Левифлоксацин		Шахмал /бүрхүүлтэй шахмал	100мг,250мг,500мг	
15	Линезолид		шахмал	600мг	
16	Рифампицин		капсул	75мг,150мг	
17	Рифапентин		бүрхүүлтэй шахмал	150мг	
18	Этамбутол		шахмал	100мг,275мг,400мг	
19	Пиразинамид		шахмал	150мг,400мг	
Эдгээр эмийн хослол					
20	Алпразолам		Сэтгэц, зан үйлийн эмгэг	шахмал	0.5мг
21	Амитриптиллин	шахмал/бүрхүүлтэй шахмал		10мг,25мг	
22	Галоперидол	шахмал		5мг	
23	Диазепам	шахмал/бүрхүүлтэй шахмал		2мг,5мг	

24	Дисульфирам	Уналт таталт, Эпилепси	бүрхүүлтэй шахмал/шахма л	250мг,500мг
25	Кветиапиний фумарат		шахмал	25мг,100мг
26	Левомепромаз ин		шахмал	25мг
27	Литийн карбонат		шахмал	300мг
28	Миртазапин		бүрхүүлтэй шахмал	15мг
29	Налтрексон		бүрхүүлтэй шахмал	50мг
30	Оланзапин		аманд задрах шахмал	5мг,10мг,15мг,20мг
31	Оланзапин		бүрхүүлтэй шахмал/шахма л	2.5мг,5мг,10мг
32	Рисперидон		шахмал	0.5мг,1мг,2мг,3мг,4мг
33	Сертралин		бүрхүүлтэй шахмал	50мг
34	Фенобарбитал		шахмал	5мг,100мг
35	Флуоксетин		капсул	20мг
36	Хлорпромазин		шахмал	100мг
37	Эсциталопрам		шахмал	10мг,20мг
38	Баклофен		шахмал	10мг
39	Вальпроат натри		сироп	50мг/мл, 57,64мг/мл
40	Вальпроны хүчил		уртасгасан үйлчилгээтэй мөхлөг	100мг
41	Вальпроны хүчил + Вальпроат натри		бүрхүүлтэй шахмал	300мг,500мг
42	Вигабатрин		шахмал	500мг
43	Вигабатрин		капсул	500мг
44	Диазепам		шулуун гэдэсний гель	10мг-2.5мл, 5мг-2.5мл
45	карбамазепин		уртасгасан үйлчилгээтэй шахмал/шахма л/бүрхүүлтэй шахмал	200мг
46	клоназепам		шахмал	0.5мг, 2мг
47	Лакосамид		шахмал	50мг,100мг,200мг
48	Ламотриджин		шахмал	2мг,5мг,25мг,50мг,100мг
49	Леветирацетам		шахмал/бүрхүү лтэй шахмал	250мг,500мг,750мг,1000мг
50	Леветирацетам		уусмал	100мг/мл
51	Натрийн дивалпрокс		шахмал	250мг,500мг
52	Оскарбазепин		суспензи/сироп	60мг/мл-100мл
53	Оскарбазепин		шахмал	150мг,300мг,600мг

54	прегабалин	Хорт хавдрын 3,4 үе шат /Хөнгөвчлөх эмчилгээ/	капсул/бүрхүүл тэй капсул	75мг,150мг,300мг	
55	прегабалин		шахмал	75мг,150мг	
56	Кодеинфосфат		шахмал	30мг	
57	Кодеинфосфат + Парацетамол		лаа	60мг+1000мг	
58	Кодеинфосфат + Парацетамол		шахмал	30мг+500мг	
59	Морфин		туншилтай тарилгын уусмал	1%-1мл	
60	Морфин, даруй сулардаг		шахмал	10мг	
61	Морфин, удаан сулардаг		шахмал	30мг	
62	Трамадол		дусал		
63	Трамадол		капсул	50мг,100мг	
64	Трамадол		туншилтай тарилгын уусмал	50мг/мл, 75мг/3мл, 100мг/2мл	
65	Трамадол		шахмал	50мг,100мг	
66	Бевацизумаб		Хорт хавдрын бай эмчилгээний эм	Тарилгын уусмал бэлтгэх концентрат, концентраттай уусмал	25мг/мл
67	Дабрафениб			капсул	50мг,75мг
68	Иматиниб			бүрхүүлтэй шахмал	100мг,400мг
69	Лопатиниб	бүрхүүлтэй шахмал		250мг	
70	Олапариб	шахмал		100мг,150мг	
71	Осимертиниб	шахмал		40мг,80мг	
72	Офатумумаб	тарилгын уусмал		20мг-0.4мл	
73	Пазопаниб	бүрхүүлтэй шахмал		400мг	
74	Пертузумаб	концентраттай уусмал		420мг/14мл	
75	Рибоциклиб	бүрхүүлтэй шахмал		200мг	
76	Траметиниб	бүрхүүлтэй шахмал		0.5мг,2мг	
77	Трастузумаб	Тарилгын нунтаг		150мг,440мг,600мг	
78	Церитиниб	шахмал		150мг	
79	Эрлотиниб	шахмал		100мг,150мг	
80	Сорафениб	шахмал		200мг	
81	Палбоциклиб	бүрхүүлтэй шахмал		75мг	
82	Эверолимус	шахмал		2.5мг,5мг,10мг	

83	Нилотиниб		капсул	150мг,200мг
84	Ритуксимаб		тарилгын уусмал бэлтгэх концентрат	500мг-50мл,100мг-10мл,1400мг/11.7мл-15мл
85	Руксолитиниб		шахмал	5мг,15мг
86	Атезолизумаб*	Хорт хавдрын дархлаа эмчилгээ	тарилгын шингэн бэлтгэх концентрат	840мг/4мл,1200мг/20мл
87	Гидроксиуреа	Цочмог промиелоцитын лейкеми, Архаг лимфолейкеми лимфомууд, Архаг миелопролиферати в эмгэгүүд	капсул	200мг,300мг,400мг,500мг
88	Преднизолон		бүрхүүлтэй шахмал/шахмал	5мг,25мг
89	Метотрексат		шахмал	2.5мг
90	6-меркаптопурин		шахмал	50мг
91	Метилпреднизолон	Тархмал хатуурал	шахмал	16мг,32мг
92	Десмопрессин	Чихрийн бус шижин	хамрын цацлага	0.1мг/мл-5мл
93	Десмопрессин		шахмал	0.1мг,0.2мг
94	Гликлазид	Чихрийн шижин	шахмал	30мг,60мг,80мг
95	Инсулин		тарилгын уусмал/суспензи/тариур	100 ОУН/мл-3мл, 100 ОУН/мл-10мл
96	Метформин		шахмал	500мг,850мг
97	Микофенолат мопетил	Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал	шахмал, капсул	180мг,250мг,360мг,500мг
98	Такролимус		капсул	0.5мг,1мг,5мг
99	Циклоспорин		капсул	25мг,50мг,100мг
100	Эверолимус		шахмал	0.25мг,0.75мг,2.5мг,5мг,10мг